



ХӨШИГИЙН ХӨНДИЙН
НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ ТӨХХК

Үйл ажиллагааны тайлан 2023



75114323, 75114303



info@khkhap.mn



www.khkhap.mn

АГУУЛГА

- 1. Үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан**
 - 1.1 Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийн хэрэгжилт**
 - 1.1.1 Тайлант хугацааны онцлох үр дүнтэй ажлууд**
 - 1.1.2. “Чингис хаан” олон улсын нисэх буудлын өнөөгийн байдал, үйлчилгээний тоон үзүүлэлт**
 - 1.1.3 Хамтарсан компанийн санхүүгийн байдал, үр дүн, хөрөнгө оруулалтын өгөөж, үр ашиг**
 - 1.2 Төрийн хүндэт зочны танхимын үйл ажиллагаа, үйлчилгээ, үр дүн**
- 2. Компанийн менежмент, хүний нөөцийн үйл ажиллагааны тайлан**
 - 2.1 Компанийн хүний нөөцийн үйл ажиллагаа**
 - 2.2 Хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаа**
- 3. Компанийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан**
 - 3.1 Үйл ажиллагааны орлого**
 - 3.2 Үйл ажиллагааны зардал**
 - 3.3 Хөрөнгө оруулалт**
 - 3.4 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**
- 4. Компанийн үйл ажиллагааны тайлагнал**
- 5. 2023 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны биелэлтийн дэлгэрэнгүй**

“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” /ХХНОБ/ ТӨХХК-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 150 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдсанаас хойш 5 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 322 дугаар тогтоолын дагуу уг төслийг хэрэгжүүлэгч Монгол Японы хамтарсан “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн Монголын талд ногдох 49 хувийн Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компани нь 2023 онд дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд үндсэн 2 төрлийн үйл ажиллагааг эрхлэн тайлант жилд компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн ХЭХТ-22/07 дугаар тогтоолоор батлуулсан 2023 оны бизнес төлөвлөгөөг оны эхнээс хэрэгжүүлэн дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний биелэлтийг 100 хувь хангаж ажиллалаа.

1/. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Компани 2023 онд Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх, Төрийн хүндэт зочны танхимын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, Компанийн засаглалыг сайжруулах, тогтвортой хөгжлийг хангах, Санхүүгийн ил тод байдлыг хангаж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хөтөлж, зөрчилгүй тайлагнах гэсэн үндсэн 4 зорилтыг дэвшүүлэн нийт 28 ажил, арга хэмжээний биелэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

1.1. Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийн хэрэгжилт

Тайлант хугацаанд “Чингис хаан” ОУНБ (Олон улсын нисэх буудал)-ын үйл ажиллагаа, үйлчилгээ тасралтгүй, тогтвортой явагдаж жигдэрсэн ба компанийн санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн үзүүлэлт өнгөрсөн оноос өсч, орлого төлөвлөснөөс давж биелсэн, тайлант жилийн эцэст хуримтлагдсан алдагдлаа бүрэн нөхөж жилийн дүнгээр 48.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, хуримтлагдсан ашиг 33.5 тэрбум төгрөгт хүрсэн.

Компанийн зүгээс хамтарсан компанийн хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, хамтарсан компанийн Концессын гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг идэвхтэй явуулж хамтарсан компанид хувьцаа эзэмшигчийн зүгээс өгөх санал дүгнэлт, зөвлөмж чиглэлийг байнга өгч, дэмжлэг үзүүлэн, хамтарсан компанийн удирдлага, 51 хувийн хувьцаа эзэмшигч, салбарын яам, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Тайлант жилд буюу 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хамтарсан компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас (ХЭХ) Хувьцаа эзэмшигчдийн хурлын 10 тогтоол (“ХЭХТ”) үйлдэж баталгаажуулсан. Үүнд:

Компанийн тухай хуульд зааснаар “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хуралдуулж хамтарсан компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэсэн

Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж баталсан ба мөн компанийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан.

Хамтарсан компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Японы талын гишүүдийг “Жапан эйрпорт менежмент” ХХК-ийн хүсэлтийн дагуу чөлөөлөх, томилох асуудлыг судлан танилцаж ТУЗ-ийн 2, гишүүнийг чөлөөлж, чөлөөлөгдсөн 2 гишүүний оронд шинээр 2 гишүүнийг томилох асуудлыг хэлэлцэж томилон шийдвэрийг баталгаажуулсан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монголд зочлох жил зэрэг Засгийн газрын бодлого, Зам, тээврийн хөгжлийн яамнаас өгсөн үүрэг чиглэлийн хүрээнд “Чингис хаан” ОУНБ-ын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой авч хэрэгжүүлж буй ачааны туузан дамжуургын өргөтгөл, зорчигч үйлчлүүлэгчид зориулсан зай талбайг нэмэгдүүлэх, нисэх буудлын гадна орчны өнгө үзэмж, тохижилт үйлчилгээ, ногоон байгууламж, зүлэгжүүлэлт, үерийн далан, онгоцны шувуутай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, нийтийн тээврийн асуудлуудыг хэлэлцэж, тайлбар тодруулга авч, дээрх ажлуудад зөвлөмж дүгнэлт өгч хамтран ажилласан.

Хамтарсан компанийн Монголын талын буюу компанийг төлөөлөх ТУЗ-ийн гурван гишүүнийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх нийт 42 асуудлаар баримтлах чиглэл, хуралд оролцох удирдамжаар тухай бүр хангаж ажиллаж тайлант хугацаанд нийт 9 удирдамжийг ТУЗ-ийн гишүүдэд хүргүүлсэн байна.

Хамтарсан компанийн ТУЗ-ийн хурлаас ТУЗ-ийн нийт 31 тогтоол (ТУЗТ) батлагдсаны дагуу тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Эдгээр тогтоолуудаар тус компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов, “Чингис хаан” ОУНБ-ын олон улсын явагчийн танхим дахь түрээслэгчдийг шилжүүлж шинээр зорчигчдод зориулсан үйлчилгээний зай талбай гаргах ажлын санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлын талаар, мөн ТУЗ-ийн дарга Андо Айсүкийн ажиллах хугацааг 1 жилээр сунгах болон Япон ажилтнуудын ажилтан түр шилжүүлэх гэрээ, компанийн хувьцаа эзэмшигч болох “ЖЭМ” (Жапан Эйрпорт Менежмент) ХХК болон “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” (“ХХНОБ”) ТӨХХК-д олгох зээл, зээлийн гэрээг хэлэлцэх, хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, орлон ажиллах эрх олгох, Япон талын 2 газрын даргыг чөлөөлж, томилох, сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох, нэмэлт бүртгэлийн цэг нийлүүлэх, суурилуулах ажлын талаар тус нисэх буудалд ачаа тээшний туузан дамжуургыг анх суурилуулсан үйлдвэрлэгчтэй хэлэлцээ хийх эрх олгох, төсөвт тодотгол хийх, компанийн бүтэц, зохион байгуулалт болон худалдан авах ажиллагааны журмыг шинэчлэн батлах, компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт оруулах өөрчлөлт, 2023 оны болзошгүй зардлын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмж худалдан авах ажлуудад зөвшөөрөл олгох, ЖАЛУКС Инк болон ЖАТКО ХХК-тай байгуулах Ажилтан түр шилжүүлэх гэрээг шинэчлэх, 2023 оны болзошгүй зардлын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнүүд, тоног төхөөрөмж худалдан авах ажлуудад зөвшөөрөл олгох болон “НУБИЭ” ХХК-ийн 2024 оны Бизнес төлөвлөгөө батлах зэрэг асуудлуудын талаар хэлэлцэн шийдвэрлэсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэр:

Д/д	ХЭХ-ийн хурал:			Д/д	ТУЗ-ийн хурал:		
	Он сар өдөр	Тогтоол	Тэмдэглэл		Он сар өдөр	Тогтоол	Тэмдэглэл
1	2023.03.22	4		1	2023.03.30	4	1
2	2023.04.20	1	1	2	2023.05.15	1	
3	2023.09.12	1		3	2023.07.03	8	1
4	2023.11.02	2		4	2023.09.12	7	
5	2023.12.11	2		5	2023.10.25	1	
6	2023.12.21			6	2023.11.03	2	
				7	2023.11.30	3	
				8	2023.12.21	5	
Нийт тоо		10	1	Нийт тоо		31	2

Мөн хамтарсан компанийн ХЭХ болон ТУЗ-ийн хурлаас гадна *хамтарсан компанийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчдийн хамтарсан хурал, уулзалтыг нийт 42 удаа* зохион байгуулж Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, чиглэл болон Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал, албан даалгавар, шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын талаар хэлэлцэн, санал, зөвлөмж өгч, үүрэг даалгаврын хэрэгжилт, биелэлтийг хянах, биелэлтийн тайланг бэлтгэхэд хамтран ажиллах, тухай бүр заасан хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яам (“ЗТХЯ”), холбогдох байгууллагад хүргүүлж тайлагнах, мэдээлэл өгөх, танилцуулга хийх зэргээр хамтран ажилласан.

Нисэх буудлын үйл ажиллагаанд олон улсын стандарт, Монгол Улсын хууль эрхзүйн хэм хэмжээний хэрэгжилтийг хангуулахад концесс эзэмшигч буюу нисэх буудлын менежментийг хэрэгжүүлэгч хамтарсан компани, тус компанийн хувьцаа эзэмшигчид идэвхтэй хамтран ажиллаж байна.

Бидний хамтын ажиллагааны үр дүнд “Чингис хаан” ОУНБ нь одоогийн барилга байгууламжийн хүчин чадал, барилгын зураг төсөлд нийцүүлэн нисэх буудлын ачаалал бөөгнөрлийг бууруулах, үйлчилгээг сайжруулах боломж нөхцөлийг судалж, нэн түрүүнд авч хэрэгжүүлэх боломжтой арга зам, шийдлийг тодорхойлон хэрэгжүүлэхэд анхаарч олон үр дүнтэй санал, шийдвэр, зөвлөмж, дүгнэлтийг ажил хэрэг болгон хэрэгжүүлж нисэх буудалд үүсээд байсан зарим тодорхой асуудлыг шийдвэрлэсэн.

Эдгээр арга хэмжээний үр дүнд “Чингис хаан” ОУНБ-ын үйлчилгээг сайжруулахад чиглэсэн хэд хэдэн онцлох, томоохон үр дүнтэй ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.
/Тайлангийн 1.3 дахь хэсэгт дэлгэрэнгүй дурдав/



1.1.1. Тайлант жилийн онцлох үр дүнтэй ажлууд:

Засгийн газрын 2022 оны 228 дугаар тогтоолын хүрээнд “Чингис хаан” ОУНБ-ын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, зорчигчдод үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх, ачаалал, бөөгнөрлийг бууруулах, үйлчилгээг хурдан шуурхай үзүүлэхэд чиглэсэн одоогийн барилга байгууламжийн хүчин чадал, барилгын зураг төсөл, бодит байдлыг харьцуулан судалсан хувьцаа эзэмшигчид болон хамтарсан компанийн ажлын хэсгийн 2022 онд хийсэн судалгаа дүгнэлт, Концессын гэрээнд заасны дагуу 2023 оны 07 дугаар сард боловсруулсан Мастер төлөвлөгөөний санал дүгнэлтэд үндэслэн концесс эзэмшигчээс нэн түрүүнд авч хэрэгжүүлэх боломжтой арга зам, шийдлийг тодорхойлсны дагуу хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий этгээдүүдтэй харилцан зөвшилцөж зөвшөөрөл авах, хамтарсан компани өөрөө бие даан шийдвэрлэх замаар хэд хэдэн үр дүнтэй ажлыг концесс эзэмшигч хариуцан гүйцэтгэсэн.

Эдгээр ажлыг хэрэгжүүлэхэд хувьцаа эзэмшигчийн зүгээс манай компани шаардлагатай бүх дэмжлэг, туслалцаа, санал зөвлөмжийг өгч хамтран ажилласан.

Бидний хамтын ажиллагааны үр дүнд “Чингис хаан” ОУНБ-д 2023 онд хийж гүйцэтгэсэн дараах үр дүнтэй ажлуудыг онцолж танилцуулав. Үүнд:

- Концессын гэрээнд заасны дагуу “Чингис хаан” ОУНБ-ын “Мастер төлөвлөгөө”-г боловсруулж батлуулан эрх бүхий байгууллагуудад хүргүүлсэн.




- Олон улсын ирэгчийн танхимд тус бүр нь 36м урттай ачаа тээшний 3 ширхэг туузан дамжуургын 2-ыг нь 60м урттай болгон өргөтгөсөн. Ингэснээр том оврын агаарын хөлгийг нэг туузан дамжуурга дээр дангаар нь хүлээн авах боломжтой болж ачаа тээшийг нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдсэн,



- E-gate буюу хилийн цахим бүртгэлийн гарц (Automated Border Control Gates буюу E-Gate) 8 ширхгийг нэвтрүүлснээр Монгол Улсын иргэд гадаадад зорчих болон гадаадаас ирэхдээ шалган нэвтрүүлэх цэгээр паспортоо тусгай төхөөрөмжид уншуулан дараалалгүй, хялбар, шуурхай хилээр нэвтрэх боломжтой болсон,



- Ирэгчдийн танхимын зарим хана, өрөө тасалгааг буулгаж зорчигчдод зориулсан зай талбайг 188 м²-аар нэмэгдүүлсэн,





- 2 дугаар давхрын олон улсын явагчийн танхимын зай талбайг 146 м²-аар нэмэгдүүлж, “IATA”-ийн Оптимум түвшин 12-рт заасны дагуу 80~110 зорчигчийн талбай нэмэгдсэн үр дүн гарсан,

Зорчигчдод зориулсан зай талбай **146м²-аар нэмэгдсэн** бөгөөд энэ нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандартаар **80-110 зорчигчийн зай талбайг бий болгосон.**



- Хилийн шалган нэвтрүүлэх цэгийн ойролцоох оффисын өрөөг буулгаж, зорчигчийн талбайг 154.4м²-аар томруулсан. Ингэснээр “IATA”-ийн Оптимум түвшин 12-рт заасны дагуу 120~150 зорчигчийн талбай нэмэгдсэн.
- Ачаа тээш авах танхимаас гарах хаалганы хэсэгт бөөгнөрөл үүсэхээс зайлсхийж Гаалийн үзлэгийн өрөөг буулган зорчигчийн гарах хаалганы зайг 33.6м²-аар томруулах шийдлийг олж “IATA”-ийн Оптимум түвшин 12-рт заасны дагуу 18~25 зорчигчийн талбай нэмэгдсэн,



- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-ын Universal security audit Programme – Continuous Monitoring approach хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хийх аудит шалгалтын бэлтгэл ажлыг ханган 2023 оны 10 дугаар сард холбогдох төрийн болон хувийн байгууллагуудтай хамтран аудитын шалгалтад амжилттай хамрагдсан.
- Онцгой нөхцөлийн КОД-7 "Барилга байгууламжийг тэсрэх хэрэгслээр заналхийлэх үйлдэл" сэдэвт бүрэн хэмжээний дасгал сургуулилтыг Монгол Улсын Терроризмтой тэмцэх зөвлөл, Тагнуулын ерөнхий газар болон "Чингис Хаан" ОУНБ хамтран "Хаан шонхор - 2023" нэрэн дор 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр амжилттай зохион байгуулсан.
- "Чингис хаан" ОУНБ-ын хөөрч буух зурвас нь хоёр талын оролттой бөгөөд үүнтэй холбоотойгоор хөөрч буух зурвасын хүчин чадал ихсэн цаг агаараас шалтгаалсан нислэгийн саатал "Буянт-Ухаа" ОУНБ-тай харьцуулахад 2.5 хувиар багассан. Цаг агаарын тааламжгүй байдал, салхины чиглэлээс шалтгаалах нислэгийн саатал "Буянт-Ухаа" ОУНБ-ын хувьд 2.3% байсан бол "Чингис хаан" ОУНБ-ын хувьд 0.5%-д хүртэл буурсан үзүүлэлттэй байна. (1000 нислэгт 5 саатал хүртэл) Нисэх буудлын ашиглалт одоогийн байгаа 73%-аас 98%-д хүрнэ (олон улсын стандарт 95%).
- Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Чингис хаан" ОУНБ-ын аэродромын хучилтын даацын талаарх нисэхийн судалгааг хийсний үндсэн дээр тус нисэх буудалд шинээр ашиглагдахаар төлөвлөгдөж буй B777-300ER, B787-900 Олон улсын иргэний нисэхийн тухай "Чикагийн Конвенц"-ын "Док 9157"-ийн 3 бүлэгт заасны дагуу тус агаарын хөлгүүд нь "Чингис хаан" ОУНБ-д ямар нэгэн жингийн хязгаарлалтгүй хөөрөлт буултыг үйлдэх боломжтой болсон.
- Инженерийн дэд бүтцийн чиглэлийн үйл ажиллагаа "Буянт-Ухаа" ОУНБ-тай харьцуулахад ихээхэн өргөжсөн. Тухайлбал, "НУБИЭ" ХХК нь нисэх буудлын барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг хариуцан ажиллахын зэрэгцээ дулаан үйлдвэрлэх, түгээх, гүний ус олборлох, түгээх болон цахилгаан түгээх үйлчилгээг холбогдох тусгай зөвшөөрлийн дагуу бие даан явуулж байна.
- Бүртгэлийн цэгийн зорчигч урсгалыг сайжруулж, бөөгнөрлийг багасгах хамтын ажиллагааны үүрэг, хариуцлагын заагийг тодорхойлж, харилцан тохиролцож агаарын тээвэрлэгч буюу "МИАТ" ТӨХК-тай санамж бичгээр харилцан тохиролцож, санамж бичгийн хэрэгжилт, явцын талаар өдөр тутмын ээлжийн тайлан мэдээг "МИАТ" ТӨХК руу илгээж, мэдээлэл солилцон хамтын ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажилласан,
- Иргэний нисэхийн ерөнхий газар ("ИНЕГ")-ын Нислэгийн цагийн хуваарийн зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж олон улсын нислэгийн цаг ачаалалд хийсэн судалгаа, дүгнэлтийг танилцуулснаар өвөл, зуны цагийн хуваарьт нисэх буудлын саналыг тусгуулж батлуулсан.

1.1.2. "Чингис хаан" олон улсын нисэх буудлын өнөөгийн байдал, үйлчилгээний тоон үзүүлэлт:

"Чингис хаан" ОУНБ нь нисэх буудлын үйлчилгээг тасралтгүй, тогтвортой явуулж, зорчигч үйлчлүүлэгчдэд тав тухтай, хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэх, нисэх буудлын

аюулгүй ажиллагааг хангаж ажиллах үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд гол анхаарлаа чиглүүлж байна.

Концессын гэрээнд заасны дагуу нисэх буудлын үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотойгоор ИНЕГ-аас концессын зүйлд хамаарах нийт 47 барилга байгууламж, холбогдох тоног төхөөрөмжүүд олон концессын талбайг хүлээн авсан ба эдгээр нь “Чингис хаан” ОУНБ-ын үйл ажиллагааг эрхлэн явуулах суурь хөрөнгө юм.

Компани 2023 оны байдлаар 658 үндсэн ажилтан, 34 гэрээт ажилтантай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ихэнх нь иргэний нисэхийн салбарт олон жил ажилласан, Концессын гэрээний дагуу ИНЕГ-аас шилжиж ирсэн ажилтнууд байна.

“Чингис хаан” ОУНБ-ын статистик тоон үзүүлэлтийн тайлан мэдээгээр 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт нислэгийн тоо **14,901**, үүнээс олон улсын **9,581** орон нутгийн **5,320** нислэг хүлээн авсан ба нийт зорчигчийн тоо **1,745,293**, үүний **1,323,667** нь олон улсын зорчигч, **421,606** нь орон нутгийн зорчигч байна.

Энэ нь нийт зорчигчийн тоо өмнөх 2022 онтой харьцуулахад 182.2 хувиар, 2019 онтой харьцуулахад 108 хувиар, Нислэгийн тоо 2022 онтой харьцуулахад 155.8 хувиар тус тус өссөн үзүүлэлт байна.




1.1.3. Хамтарсан компанийн санхүүгийн байдал, үр дүн, хөрөнгө оруулалтын өгөөж, үр ашиг:

“Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн 2023 оны үйл ажиллагааны орлогын нийт дүн /2023.12.31-ний өдрийн байдлаар/ гүйцэтгэлээр 124.8 тэрбум төгрөг, орлогоос тооцож төлөх концессын төлбөрийн дүн 11.8 тэрбум төгрөг байсан. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 1.8 дахин, концессын төлбөр 1.9 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант жилийн гүйцэтгэлээр концессын төлбөрийн нийт дүн 11.8 тэрбум төгрөг ба энэ нь өнгөрсөн оноос 1.9 дахин буюу 193 хувиар өсөж зорилтот түвшин давж биелж байна.


“Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн хувьд 2024 оноос эхлэн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаар төлөвлөсөн. Тус компанийн 2023 оны жилийн гүйцэтгэлээр тайлант онд 48.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, хуримтлагдсан алдагдлаа бүрэн нөхөж, хуримтлагдсан ашиг 33.5 тэрбум төгрөгт хүрсэн.

2024 оны 1 дүгээр улиралд багтаан ТУЗ-өөс ногдол ашгийн бодлогыг баталж, эхний хагас жилд багтаан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилна.



Концессын төлбөрийн тооцоолол /мян.төг/:

Д / Д	Оноор:	Нийт орлого	Концессын төлбөр	Улсын төсөвт төлсөн нийт төлбөр (албан татвар, төлбөр хураамж)
1	2021 он	13,575,349	1,193,454	331,331
2	2022 он	68,345,953	6,151,136	14,398,831
3	2023 он	124,818,858	11,756,893	26,614,572



Хуримтлагдсан ашгийн тооцоо /мян.төг/

Д/д	Үзүүлэлт – гүйцэтгэлээр:	2021 он	2022 он	2023 он
1	Нийт орлого	13,239,023	68,345,953	124,818,858
2	Нийт зардал	29,588,503	50,352,252	71,502,678
3	Тайлант оны цэвэр ашиг	-15,939,495	19,044,246	48,287,416
4	Хуримтлагдсан ашиг /алдагдал/	(-33,878,451)	(14,773,700)	33,513,719

1.2. Төрийн хүндэт зочны танхимын үйл ажиллагаа, үйлчилгээ, үр дүн

Хүндэт зочны танхимын үйлчилгээг тасралтгүй 24 цагаар 4 ээлжээр, үйлчилгээний хэвийн байдлыг ханган, түргэн шуурхай, доголдолгүй үзүүлж байна.

Хүндэт зочны албаны үйлчилгээнд нийт 24 ажилтан ажил үүрэг гүйцэтгэх орон тоо, зохион байгуулалтыг хийж 2023 оноос эхлэн үйлчилгээний ажилтны сул орон тоог бүрэн нөхөх, ажлын ачаалал, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан ба 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хүндэт зочны танхимын үйлчилгээнд 20 ажилтан үйлчилгээ үзүүлж байна.

Компанийн эрхлэн явуулж буй Төрийн “Хүндэт зочны танхим”-ын үйлчилгээнд Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Зам, тээврийн хөгжлийн сайд, Гадаад харилцааны сайд нарын хамтарсан 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 33, А/24, А/101 тоот тушаалаар батлагдсан “Төрийн хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам”, “Хүндэт зочны танхимын ажиллах заавар” зэрэг бусад хууль, журмын дагуу Монгол Улсын төрийн өндөр албан тушаалтан, тэдгээрийн зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтан, гадаадын өндөр, дээд хэмжээний зочин, төлөөлөгч, Монгол Улсад суугаа гадаад орны болон Монгол Улсаас гадаад оронд суугаа дипломат байгууллагын тэргүүнүүдийг гадаадад явах болон ирэх үед “Чингис хаан” ОУНБ-д угтах, үдэх үйлчилгээ, албан айлчлалын бүрэлдэхүүн, төрийн ёслол хүндэтгэлийн үйлчилгээний байнгын бэлэн байдлыг хангаж, танхимын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна.

Хүндэт зочны танхимаар үйлчлүүлэгчдэд ая тухтай, аюулгүй, шуурхай, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэхэд “Хилийн цэргийн 0218 дугаар анги”, “Нисэхийн гаалийн газар”,

“Гадаадын иргэн, харьяатын газар”, “НУБИЭ” ХХК, “МИАТ” ТӨХК, “Аэро Монголиа” ХХК, “Хүннү эйр” ХХК болон бусад авиа компаниуд, холбогдох бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслолын газрын 1369, Гадаад хэргийн яамны Дипломат ёслолын газрын 284, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн 615, нийт 2,268 зөвшөөрлийн хуудсаар 7,953 зорчигч, угтагч, үдэгч, үйлчлүүлэгчдийг угтан авч, үдэн гаргах үйлчилгээ үзүүлсэн.

“Хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам”-ын дагуу 2023 онд нийт 3,111 үйлчлүүлэгчдэд 747.8 сая төгрөгийн төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлсэн байна.

Хүндэт зочны танхимын жилийн нийт орлогын төлөвлөгөө 759.6 сая төгрөг. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн гүйцэтгэлээр 1,056.7 төгрөгийн орлого олж 139 хувиар давж биелсэн.

4. ТӨРИЙН ХҮНДЭТ ЗОЧНЫ ТАНХИМ

2023 оны жилийн эцсийн байдлаар



2/. КОМПАНИЙН МЕНЕЖМЕНТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Компанийн засаглалыг сайжруулах, тогтвортой хөгжлийг хангах зорилтыг хангахад чиглэсэн хүний нөөцийн бодлогыг баримтлан, хүний нөөцийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллав.

2.1. Компанийн хүний нөөцийн үйл ажиллагаа

Компанийн бүтэц, орон тоог оновчтой төлөвлөхийг зорьж дотоод зохион байгуулалтын нэгжийн бүтэц, чиг үүрэг, ажил үүргийн хуваарийг өөрчлөн зохион байгуулж, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 12 дугаар сарын хурлаар бүтэц, орон тоог шинэчлэн батлуулсан.

Батлагдсан бүтэц, орон тооны дагуу 2023 оны 01 дүгээр сард албан тушаалын тодорхойлолтуудыг ажилтны ажлын байрны чиг үүрэг, зорилго, зорилт, гүйцэтгэх ажил

үүрэг, хариуцлага болон албан тушаалд тавигдах шаардлагыг тухайн ажлын байрны ажил үүргийн онцлог, шаардагдах мэдлэг, чадвар, туршлага, хөдөлмөрийн зах зээлийн бодит нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн боловсруулж батлан, мөрдүүлж байна.

Бүтэц, орон тоог шинэчлэн зохион байгуулж, албан тушаалын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгосноор нэгж, хэлтэс, албаны ажлын ачааллыг оновчтой, зөв хуваарилах, ажлын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг дээшлүүлж, хариуцлагын тогтолцоог сайжруулахыг зорин ажиллаж байна.

Хүндэт зочны танхимын үйлчилгээг бие даасан албаны зохион байгуулалтад оруулж, орон тоог нэмэгдүүлснээр танхимын ажил үйлчилгээний чанар, хүртээмж, үүрэг хариуцлагыг сайжруулах, ажлын ачааллыг зөв хуваарилах зэргээр үйлчилгээг тасралтгүй, хэвийн, түргэн шуурхай үзүүлэх зорилтыг хангахад үр дүнтэй нөлөө үзүүлсэн.

Албаны орон тоог нэмэгдүүлсний дагуу сул орон тоонд ажилтан шалгаруулах үйл ажиллагааг хэд хэдэн удаа нээлттэй зарлан сонгон шалгаруулалтыг явуулж өнөөдрийн байдлаар ээлжийн бүх үйлчилгээний ажилтны орон тоо бүрэн болсон байна.

Компанийн зүгээс хүний нөөцийн чадавх, тогтвортой байдалд анхаарч ажиллаж байгаа ба зарим тохиолдолд нэн шаардлагатай ажилтны орон тоог бүрэн бүрдүүлэх, тогтвортой хүний нөөцийг бий болгоход ажлын байрны шаардлагад нийцэх ажил горилогч ховор, эсвэл ажлын байрны нөхцөл шаардлагад нийцүүлэн ажиллах сонирхолтой ажил горилогч олдохгүй байх, алслагдмал ажлын байр, орон нутгийн идэвхтэй хөдөлмөр эрхлэх ажил горилогч ховор зэрэг хөдөлмөрийн зах зээлийн нийтлэг олон хүчин зүйлүүд нөлөөлөх тохиолдол гарч байна.

Мөн өнгөрсөн хугацаанд 3 хэлтэстэй байсныг өөрчилж 2 хэлтэстэй болгосноор удирдах албан тушаалын орон тоог хасаж, оффисын нийт 4 орон тоо хасагдсан. Үр дүнд нь ажилтнууд хоорондын ажил үүргийн хийдлийг арилгах, ачааллыг тэнцүүлэх ач холбогдолтой болсон ба мөн удирдах албан тушаалтны ажлын ачаалал, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн.

Тайлант жилийн хувьд компанийн мөнгөн хөрөнгийн хүрэлцээ, санхүүгийн нөхцөлийг харгалзан зарим орон тоог хэмнэж, албан тушаал, ажил үүргийг хавсран, хослон гүйцэтгүүлэх хэлбэрээр ажилласан.

Өнөөдрийн байдлаар компанийн өдөр тутмын үйл ажиллагаа буюу захиргаа, хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, компанийн үйл ажиллагааны тайлан мэдээг бэлтгэх, тайлагнах, мэдээлэх, дээд шатны байгууллага, хувьцаа эзэмшигчтэй харилцах зэрэг ажил үүргийг бүхэлд нь Санхүү, захиргаа удирдлагын хэлтэс хариуцан гүйцэтгэж байна.

Нисэх буудлын зохицуулалтын хэлтэс нь “НУБИЭ” ХХК буюу “Чингис хаан” ОУНБ-ын үйл ажиллагаа, үйлчилгээнд хяналт тавьж шаардлагатай нөхцөлд санал дүгнэлт, зөвлөмж өгөх, ТУЗ-ийн үйл ажиллагаанд оролцож, дэмжлэг үзүүлэх, Хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх зөвшөөрлийн хуудас, компаниас олгох зөвшөөрөлд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна.

2.2. Хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаа

Компанийн хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, ажилтныг хөгжүүлэх, мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, чадавхжуулахад чиглэсэн сургалт хөгжлийн үйл ажиллагааг компанийн 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 100 хувь хэрэгжүүлэн, нийт ажилтныг бүрэн хамруулснаар компанийн засаглал, хүний нөөцийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах болон ажилтнуудын хандлагад тодорхой үр дүн гарсан гэж үзэж байна. Үүнд:

Байгууллагын соёл, хувь хүний болон ажилтны хоорондын харилцаа хандлага, үйлчилгээний соёл стандарт, хариуцлагыг дээшлүүлэхтэй холбоотой нийт 8 төрлийн 65 цагийн танхимын сургалтуудад ажилтнууд бүрэн хамрагдсан.

Хүндэт зочны танхимын үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний ажилтнуудыг дадлагажуулах, чадавхжуулах зорилгоор үйлчилгээний стандарт болон харилцааны соёл ба хандлага 3 цагийн сургалт, хувь хүний менежмент, эерэг сэтгэлгээ 3 цагийн сургалтыг тус тус мэргэшсэн сургагч багштай хамтран 04 болон 09 дүгээр саруудад танхимаар, 2023 оны 11 дүгээр сард “Көүч Лаб” сургалтын байгууллагын үүсгэн байгуулагч, Мастер трэйнер, Бизнес көүч, “BNI Монгол” байгууллагын үүсгэн байгуулагч Э.Чинзоригтой хамтран “Байгууллагын соёл хэрхэн бий болдог вэ” сэдэвт 3 цагийн танхимын сургалтыг зохион байгуулж компанийн нийт 30 ажилтан хамрагдан байгууллагын “энгэйжмент”-ийн ойлголт, байгууллагын соёлыг бүрдүүлдэг хүчин зүйлс, эерэг хандлага бүтээмжид хэрхэн нөлөөлдөг талаар мэдлэг, мэдээлэл олж авсан.

Эдгээр сургалтууд нь сонирхолтой, үр дүнтэй, амжилттай зохион байгуулагдаж нийт ажилтнуудын сэтгэл ханамж өндөр байсан..

Мөн ХАБЭА-н сургалтыг Хүндэт зочны үйлчилгээний бүх ажилтнуудад ажлын байранд нэг удаа 04 дүгээр сард болон нийт ажилтнуудыг хамруулсан ХАБЭА-н сургалт, гарч болзошгүй галын эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт, “Чингис хаан” ОУНБ-тай танилцах байдлаар 1 өдрийн газар дээрх сургалтыг 09 дүгээр сард, нийт 3 удаагийн сургалтыг “НУБИЭ” ХХК-ийн холбогдох нэгж, мэргэжилтнүүдтэй хамтран үр дүнтэй зохион байгуулсан ба аюулгүй ажиллагааны зааварчилгааг сар бүр өгч хэвшсэн.

Ажилтныг мэргэшүүлэх чиглэлээр Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын сургалтад 3 албан тушаалтныг, мөн Компанийн засаглалын гэрчилгээ олгох буюу ТУЗ-ийн гишүүний эрх, үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг олгох сургалтад 1 албан тушаалтныг хамруулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн соёрхон баталсан “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 46 дугаар зарлигийн хүрээнд Уйгаржин монгол бичгийн 15 цагийн танхимын сургалтыг Хэл иргэншлийн эрдмийн хүрээлэнтэй хамтран 2023 оны 10 дугаар сард зохион байгуулж нийт ажилтныг хамруулж монгол бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй болсон.

3/. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Компани 2023 онд 769.6 сая төгрөгийн орлогыг өөрийн эх үүсвэрээр бүрдүүлж, 1,000.0 сая хүртэлх төгрөгийн зээлийн эх үүсвэрээр санхүүжих, үйл ажиллагааны нийт зардалд 1,896.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж тайлант оны төсвийг батлуулсан.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн гүйцэтгэлээр нийт 1,073.2 сая төгрөгийн орлого олж орлогын төлөвлөгөө давуулан биелүүлсэн ба үйл ажиллагааны зардалд нийт 1,301.2 сая төгрөг зарцуулж зээлийн санхүүжилтийг багасгах зорилгоор зардлын

хэмнэлтийг хийснээр нийт зардлыг 31%-иар бууруулан зорилтот түвшинд төлөвлөсөн алдагдлыг тодорхой хэмжээгээр бууруулж ажилласан.

Мөн зээлийн санхүүжилтийг бууруулах зорилгоор төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтуудыг хойшлуулсан. Эдгээр арга хэмжээний үр дүнд оны эцэст зээлийн төлбөрийг бүрэн барагдуулж хуримтлагдсан өр төлбөргүй ажиллав.

3.1. Үйл ажиллагааны орлого:


Орлогын төлөвлөгөөг биелүүлж 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн гүйцэтгэлээр Хүндэт зочны танхимын үйлчилгээнээс 1,056.8 сая төгрөгийн орлого олж, төлөвлөсөн орлогыг 39%-иар давуулан биелүүлсэн байна.

Мөн хүүгийн болон бусад орлогоор 16.4 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

3.2. Үйл ажиллагааны зардал:

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн гүйцэтгэлээр нийт үйл ажиллагааны зардал 1,301.2 сая төгрөг, үүнээс ерөнхий удирдлагын зардалд 696.8 сая төгрөг, Хүндэт зочны танхимын үйл ажиллагааны зардалд 558.1 сая төгрөг, элэгдлийн зардал 46.3 сая төгрөг, орлогын албан татварын зардалд 1.4 сая төгрөгийг зарцуулж, тайлант хугацаанд үйл ажиллагааны зардлын 595.7 сая төгрөг буюу 31%-ийг хэмнэсэн үр дүнтэй ажилласан.

Нийт урсгал зардлын 59.0% нь цалин хөлс болон нэмэгдэл, нийгмийн даатгалын шимтгэл 7.0%, түрээсийн зардал 5%, Хүндэт зочны үйлчилгээний танхимын ашиглалтын зардал 17%, бусад зардал 12%-ийг тус тус эзэлж байна.



Нийт зардлын гүйцэтгэл /мян.төг/

Зардлын үзүүлэлт	Төлөвлөгөө 2023 он	Гүйцэтгэл 2023	Гүйцэтгэл- төлөвлөгөө	Төлөвлөгөө/ гүйцэтгэл харьцаа
Цалин хөлс	1,029,858	773,457	-256,401	75%
НДШ-ийн зардал	128,732	96,552.34	-32,180	75%
Нийгмийн халамж, тэтгэмж, тусламж	32,900	19,885.10	-13,015	60%
Шуудан, харилцаа холбоо, интернэт	8,300	6,096	-2,204	73%
Түрээсийн зардал	70,243	70,243	0	100%
Ашиглалтын зардал	28,300	14,996	-13,304	53%
Бичиг хэрэг	5,613	4,297	-1,316	77%
Маркетингийн зардал	4,500	829	-3,671	18%
Удирдлага, менежмент, гадаад харилцааны зардал	14,377		-14,377	0%
Хүний нөөцийн үйл ажиллагааны зардал	5,000	3,246	-1,754	65%
Аж ахуй, хангамжийн материалын зардал	5,000	264	-4,736	5%
Түлш шатахууны зардал	9,720	523	-9,197	5%
Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй	2,000	80	-1,920	4%
Дотоод томилолт	-			
Гадаад томилолт	30,000	5,963	-24,037	20%
Хэвлэл захиалга	800		-800	0%
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ /тээврийн хэрэгсэл/	28,000	9,238	-18,762	33%
Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний хөлс	21,900	11,000	-10,900	50%
Банкны шимтгэл, хураамж	5,000	6,545	1,545	131%
Элэгдлийн зардал	145,511	46,285	-99,226	32%
Хүүгийн зардал		8,191	8,191	
Бусад:	15,500	6,257	-9,243	40%
ХЗТ-ын үйл ажиллагааны зардал:	305,615	216,413.50	-89,202	71%
Нийт зардал	1,896,869	1,300,361	-596,508	69%

3.3. Хөрөнгө оруулалт:

Компанийн 2023 онд шаардлагатай төлөвлөсөн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг өөрийн санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн дүнг бууруулах зорилгоор оны сүүлийн хагас жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч санхүүгийн үйл ажиллагааны үр ашиг, мөнгөн хөрөнгийн нөөц үлдэгдлийг харгалзан хөрөнгө оруулалтын 30 орчим хувийг гүйцэтгэж үлдсэн 70 гаруй хувийг хойшлуулсан.

Гүйцэтгэлээрх хөрөнгө оруулалт буюу худалдан авалтын нийт дүн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 96.7 сая төгрөг.

Хөрөнгө оруулалт /мян.төг/

Д/ д	Хөрөнгийн төрөл, нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Компьютер, тоног төхөөрөмж	83,000	74,490
2	Тавилга, эд хогшил	18,500	4,909
3	Тоног төхөөрөмж	45,400	16,778
4	Тээврийн хэрэгсэл	180,000	
5	Программ хангамж	19,900	600
	Нийт дүн	346,800	96,777

3.4. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Харьцуулалт	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйц-төл	Гүйц/төл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт						
	а/ Гол нэр төрлөөр	биет					
	б/ Үнийн дүнгээр	мян.төг					
2	Нийт орлого	мян.төг	718,856.4	769,621.6	1,073,174.7	303,553.10	139%
Үүнээс	а/ Хүндэт зочны танхимын орлого	мян.төг	708,941.3	759,621.6	1,056,772.70	297,151.10	139%
	б/ Хүүгийн болон бусад орлого	мян.төг	24,603.6	10,000.0	16,402.00	6,402.00	164%
3	Нийт зардал	мян.төг	1,056,700.0	1,896,868.7	1,301,208.0	-595,660.70	69%
	Үүнээс удирдлагын зардал	мян.төг	564,466.4	1,007,373.1	696,832.0	-310,541.10	69%
4	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	-323,155.1	-1,127,247.1	-228,033.3	899,213.80	20%
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	-324,007.2	-1,127,247.1	-229,404.3	897,842.80	20%
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	232,781.2	360,575.1	327,480.2	-33,094.90	91%
	а/ Орлогын татвар	мян.төг	852.1		1,370.9	1,370.90	
	б/ НӨАТ	мян.төг	36,453.8	39,360.0	78,733.9	39,373.90	200%
	в/ НДШ	мян.төг	143,838.2	247,165.9	181,870.9	-65,295.00	74%
	г/ Хувь хүний орлогын татвар	мян.төг	50,687.8	73,349.2	64,230.6	-9,118.60	88%
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг					
	е/ Гаалийн татвар	мян.төг					
	ё/ Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	395.7	700.0	420.1	-279.90	60%
	ж/ Бусад	мян.төг	553.6		853.7	853.70	
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг				0.00	
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	28	41	32	-9.00	78%
9	Нийт цалингийн сан	мян.төг	621,054.0	1,029,858.0	773,457.4	-256,400.60	75%
10	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	1,848.4	2,093.2	2,197.3	104.10	105%
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.5	2.5	1.2	-1.30	48%
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	5,635.2	346,800.0	96,777.3	-250,022.70	28%
13	Нийт авлага	мян.төг	2,456.0	15,000.0	17,493.4	2,493.40	117%
	Үүнээс: найдваргүй	мян.төг					
14	Нийт өглөг	мян.төг	7,938.5	1,008,000.0	17,138.4	-990,861.6	2%
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	7,938.5	8,000.0	17,138.4	9,138.40	214%
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	-	-	-		

4/. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хүрээнд компанийн 2023 онд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээнд дараах төлөвлөгөөг батлан гаргаж, хэрэгжилтийг ханган, заасан хугацаанд тайлагнан ажиллав. Үүнд:

2023 онд Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдааны үүрэг даалгавраар өгсөн нийт 146 үүрэг даалгаврын биелэлтийг заасан хугацаанд тухай бүр, мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар нийт харьяа байгууллагад өгсөн 4 (1, 2, 4, 5 дугаар) албан даалгаврын хэрэгжилтийн тайланг албан даалгавар бүрд заасан хугацаанд буюу сар, улирлаар тогтмол тайлагнаж, хэрэгжилтийг 100 хувь хангаж ажилласан.

Хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн тайланг улирал бүр, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр, Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан, компанийн Үйл ажиллагааны тайланг хагас жил, жилээр, Өвөлжилтийн бэлтгэл ажлын тайланг 8-11 дүгээр саруудад сар бүр, Гадаад арга хэмжээний тайланг жилээр нэг удаа 12 дугаар сард тус тус тайлагнан ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд шилэн дансанд тухай бүр байршуулах 120, сар бүр байршуулах 24, хагас жил бүр байршуулах 3, жил бүр байршуулах 8, нийт 155 мэдээллийг хуулийн хугацаанд зөрчилгүй, бүрэн байршуулсан ба Худалдан авах ажиллагааны тайланг нийтэд ил тод, холбогдох цахим талбаруудад хуулийн хугацаанд буюу тайлант оны жилийн гүйцэтгэлийг тайлагнасан.

Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын багц хуулиуд, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль, журамд нийцүүлэн үнэн зөв, алдаагүй бэлтгэн гаргаж, хуулийн хугацаанд тайлагнаж, баталгаажуулсан.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд аудитаар баталгаажуулан Үндэсний аудитын газар ("ҮАГ")-ын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 07/550 дугаар "Өөрчлөлтгүй" (Зөрчилгүй) дүгнэлтийг авч Зам, тээврийн хөгжлийн яаманд 2023 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 01/45, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 01/47 дугаар албан бичгүүдээр хүргүүлсэн. Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ээлжит хурлаар компанийн 2022 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын тайлан, дүгнэлтийг хэлэлцүүлж "Хангалттай" үнэлэлт дүгнэлт авсан.

ҮАГ-ын 2022 оны жилийн санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж биелэлтийн тайланг 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр 01/108 дугаар албан бичгээр тус газарт, 07 дугаар сарын 25-ны 01/100 дугаартай албан бичгээр ЗТХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс тус тус хүргүүлсэн болно.

Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, мэдээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын багц хуулиуд, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль, журамд нийцүүлэн үнэн зөв, алдаагүй бэлтгэн гаргаж, хуулийн хугацаанд тайлагнаж, баталгаажуулан Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

5. 2023 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ДЭЛГЭРЭНГҮЙ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх үр дүн	Биелэлт	Хувь
Нэг. Монгол Японы хамтарсан хуулийн этгээдийн Монгол Улсын төрийн мэдлийн 49 хувийн хувьцааг эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх, хамтарсан компанийн үр ашгийг нэмэгдүүлэх						
1.	Хувьцаа эзэмшигчдийн болон Концессын гэрээний хэрэгжилтийг хангуулах, хамтарсан компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, Монголын талын хүртэх ногдол ашгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;	Хэрэгжилтийн хувь Хэрэгжүүлэх хугацаа: 4 дүгээр улиралд	Хамтарсан компанийн 2022 оны санхүүгийн тайлан хуримтлагдсан алдагдалтай гарсан	Хамтарсан компанийн санхүүгийн тайлангийн үр дүн хуримтлагдсан алдагдлаа нөхөж, ногдол ашиг хуваарилах нөхцөл бүрдсэн байна. Ногдол ашиг 2024 оноос эхлэн олгоно гэж тооцсон.	Хувьцаа эзэмшигчдийн болон Концессын гэрээний хэрэгжилтийг хангуулах, хамтарсан компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, Монголын талын хүртэх ногдол ашгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх талаарх холбогдох судалгааг байнга хийж, саналаа хамтарсан компанийн удирдлагад танилцуулан Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-д холбогдох чиглэл, удирдамж өгч хамтран ажиллаж доорх үр дүнд хүрсэн. Үүнд: <i>2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар</i> нийт нислэгийн тоо 14,901, үүнээс олон улсын 9,581, орон нутгийн 5,320 нислэг хүлээн авсан ба нийт зорчигчийн тоо 1,745,273, үүний 1,323,667 нь олон улсын зорчигч, 421,606 нь орон нутгийн зорчигч байна. Энэ нь нийт зорчигчийн тоо өмнөх 2022 онтой харьцуулахад 182.2 хувиар, 2019 онтой харьцуулахад 108 хувиар, Нислэгийн тоо 2022 онтой харьцуулахад 155.8 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарсан. "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-ийн 2023 оны үйл ажиллагааны орлогын нийт дүн гүйцэтгэлээр 124.8 тэрбум төгрөг, концессын төлбөрийн зардал нь 11.8 тэрбум төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 1.8 дахин, концессын төлбөр 1.9 дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн Нисэхийн бус орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Чингис хаан" ОУНБ-ын Зорчигч үйлчилгээний терминалын барилга болон гадна зам талбай, авто зогсоолын талбайд эвент-арга	100

					хэмжээ зохион байгуулах журам боловсруулж, үнэ гарцыг баталсан ба Монгол Улсын Засгийн газраас зарласан “Монголд зочлох жил”-ийн хүрээнд авч буй арга хэмжээг дэмжин ажилласан. Тайлант жилийн гүйцэтгэлээр концессын төлбөрийн нийт дүн 11.8 тэрбум төгрөг ба энэ нь өнгөрсөн оноос 1.9 дахин буюу 193 хувиар өсөж зорилтот түвшин давж биелсэн. Тайлант онд хамтарсан компани 48.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж хуримтлагдсан алдагдлаа бүрэн нөхсөн ба жилийн санхүүгийн тайлангаар 33.5 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ашиг бий болсон тул 2024 оноос эхлэн компани хувьцаа эзэмшигчийн үйл ажиллагаанаас орлого олж эхлэх нөхцөл бүрдсэн.	
2.	Хамтарсан компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, шаардлагатай боломжит бүхий л арга хэмжээг авч ажиллах;	Гүйцэтгэсэн ажил, хэрэгжүүлсэн арга хэмжээ Хэрэгжүүлэх хугацаа: Улирал тутамд	Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хяналт, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хяналтын үр дүнд хамтарсан компанийн үйл ажиллагаа, үйлчилгээ сайжирч, эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.	<u>Хамтарсан компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас:</u> Хувьцаа эзэмшигчдийн хурлын 10 тогтоол (“ХЭХТ”) үйлдсэн ба ТУЗ-ийн 2 гишүүнийг чөлөөлж, 2 гишүүнийг шинээр томилж, компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, үр дүнг хэлэлцэж, ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж баталгаажуулсан. Хамтарсан компанийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг судлан танилцаж Монголын талын ТУЗ-ийн гишүүдийг тухай бүр удирдамж, чиглэлээр хангаж ажиллан 42 хэлэлцэх асуудлаар 9 удирдамж, чиглэл хүргүүлсэн. Тайлант жилийн турш хамтарсан компани, нисэх буудлын болон ТУЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хяналт тавьж хамтран ажиллав. <u>Хамтарсан компанийн ТУЗ-ийн хурлаас:</u> ТУЗ-ийн нийт 31 тогтоол гарсны дагуу хэрэгжилтийг хангуулан ажилласан. Эдгээр тогтоолуудаар компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн	100

					дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов, “Чингис хаан” ОУНБ-ын Олон улсын явагчийн танхим дахь түрээслэгчдийг шилжүүлж шинээр зорчигчдод зориулсан үйлчилгээний зай талбай гаргах ажлын санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлын талаар, мөн ТУЗ-ийн даргын ажиллах хугацааг 1 жилээр сунгах, компанийн хувьцаа эзэмшигч болох “ЖЭМ” (Жапан Эйрпорт Менежмент) ХХК болон “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” (“ХХНОБ”) ТӨХХК-д зээл олгох, хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, орлон ажиллах эрх олгох, Япон талын 2 газрын даргыг чөлөөлж, томилох, сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох, нэмэлт бүртгэлийн цэг нийлүүлэх, суурилуулах ажлын талаар тус нисэх буудалд ачаа тээшний туузан дамжуургыг анх суурилуулсан үйлдвэрлэгчтэй хэлэлцээ хийх эрх олгох, төсөвт тодотгол хийх, компанийн бүтэц зохион байгуулалт болон худалдан авах ажиллагааны журмыг шинэчлэн батлах, компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт оруулах өөрчлөлтийн талаар, ЖАЛУКС Инк болон ЖАТКО ХХК-тай байгуулах Ажилтан түр шилжүүлэх гэрээг шинэчлэх тухай зэрэг асуудлуудын талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Мөн Хамтарсан компанийн гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигчдийн хамтарсан хурал, уулзалтыг нийт 42 удаа зохион байгуулж Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого, чиглэл болон Зам, тээврийн хөгжлийн сайд (“ЗТХСайд”)-ын тушаал, албан даалгавар, шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын талаар хэлэлцэн, санал, зөвлөмж өгч, үүрэг даалгаврын хэрэгжилт, биелэлтийг хамтран гаргаж, тайлант хугацаанд нь Зам, тээврийн хөгжлийн яам (“ЗТХЯ”), холбогдох байгууллагад хүргүүлж, мэдээлэл өгөх, танилцуулга хийх зэргээр ажилласан. Нисэх буудлын үйл ажиллагаанд	
--	--	--	--	--	---	--

					олон улсын стандарт, Монгол Улсын хууль эрхзүйн хэрэгжилтийг хангуулахад концесс эзэмшигч буюу нисэх буудлын менежментийг хэрэгжүүлэгч компани, компанийн хувьцаа эзэмшигчид идэвхтэй хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны үр дүнд “Чингис хаан” ОУНБ нь одоогийн барилга байгууламжийн хүчин чадал, барилгын зураг төсөлд нийцүүлэн нисэх буудлын ачаалал бөөгнөрлийг бууруулах, үйлчилгээг сайжруулах боломж нөхцөлийг судалж авч хэрэгжүүлэх боломжтой арга зам, шийдлийг тодорхойлсноор 2023 онд “Чингис хаан” ОУНБ-д хэд хэдэн үр дүнтэй ажлуудыг гүйцэтгэсэн талаар тайлангийн 1.1.1 дэх хэсэгт дэлгэрэнгүй дурдсан болно.	
3.	Концессын гэрээний 19 дүгээр зүйлийн дагуу “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Концессын 15 жилийн хугацаа буюу 2035 он хүртэлх Мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллах;	Мастер төлөвлөгөөний хэрэгжилт Хэрэгжүүлэх хугацаа: 1,2 дугаар улиралд	Зөвлөхийн ажлын даалгавар боловсруулж байгаа	Концессын гэрээний дагуу 15 жилийн хугацааны Мастер төлөвлөгөө гарсан байна.	Зөвлөх үйлчилгээний “Мастер төлөвлөгөө”-г боловсруулах сонгон шалгаруулалтыг нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, тендерт Япон улсын 2, Монгол Улсын 1 компани оролцсоноос Япон улсын “Ориентал Консалтантс Глобал” ХК шалгарч тус компанитай 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр гэрээ байгуулсан. “Ориентал Консалтантс Глобал” ХК нь “Чингис хаан” ОУНБ-ын 2035 он хүртэлх 15 жилийн Мастер төлөвлөгөөг эцэслэн боловсруулснаар Концессын гэрээний 19 зүйлд заасан хугацаанд буюу 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдөр ЭЗХЯ, ЗТХЯ, ИНЕГ-т тус тус албан тоотгоор хүргүүлсэн. Мастер төлөвлөгөөг 2036 он хүртэлх нислэг болон зорчигчийн тооны урьдчилсан тооцооллд үндэслэн боловсруулсан ба концессын талбай болон бусад зүйлийг хамруулсан. Тус төлөвлөгөөнд эрэлтэд тулгуурлан ирээдүйд нисэх буудалд үүсэх хүндрэлүүдийг тодорхойлсон бөгөөд хэзээ, ямар өргөтгөл хийх шаардлагатай талаар санал болгосон. Харин Мастер төлөвлөгөөний хүрээнд хийх барилгын ажлын зураг төслийн болон барилга угсралтын ажлын гүйцэтгэх хугацаа, төсвийн тооцооллыг	100

					зөвхөн мэдээлэл болгон оруулсан. Тус төлөвлөгөө нь “Чингис хаан” ОУНБ-ын анхны Мастер төлөвлөгөө учир ирээдүйд хийгдэх өргөтгөлийг ерөнхий 3 хувилбараар хийх санааг дэвшүүлэн тэдгээрийн давуу болон сул талуудыг тайлбарласан. “Чингис хаан” ОУНБ-ын Мастер төлөвлөгөөг үндсэн 3 үе шаттайгаар буюу эхний үе шат буюу одоо байгаа хүчин чадлаа тооцоолох, 2036 он хүртэлх зорчигч болон нислэгийн тооны урьдчилсан таамаглалыг тооцоолж гаргах ажлыг дотоодын нөөц бололцоогоор гүйцэтгэн, 2, 3-р шатанд 1-р шатанд хийсэн тооцоолол, үр дүнг нягтлах, болзошгүй хүндрэлийг тодорхойлох, тэдгээрт тохирсон шийдлийн хэд хэдэн хувилбарыг боловсруулах, боловсруулсан шийдлүүдэд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх боломжтой, хамгийн үр ашигтай шийдлийг сонгон “ICAO” (Олон улсын иргэний нисэхийн байгууллага) болон “IATA” (Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо)-ийн Нисэх буудлын төлөвлөлтийн гарын авлага /Док-12/ зэрэг заавар, зөвлөмжийг мөрдлөг болгон цаашид тус нисэх буудлыг хөгжүүлэх, сайжруулах санал, дүгнэлтийг олон улсын зорчигч 1.5 сая, 2.0 сая, 2.3 сая болох тохиолдолд ямар нөхцөл байдал үүсэх тооцооллыг урьдчилсан байдлаар гаргасан.	
4.	Монголд Зочлох жилийн хүрээнд 2023 оны “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын бөөгнөрлийг бууруулах, зорчигч үйлчилгээний барилгын бодит тооцоот талбайг бүрэн ашиглах, нисэх буудлын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зохион байгуулалтыг холбогдох байгууллагатай хамтран	Гүйцэтгэлийн Хувь Хэрэгжүүлэх хугацаа: 1,2 дугаар улиралд Хэрэгжүүлэх хугацаа:	2022-2023 оны өвлийн цагийн хуваарийн зохицуулалт хийгдсэн. Ачаа тээш хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэхэд эрх бүхий этгээдээс /Эдийн засаг, хөгжлийн	Нислэгийн цагийн хуваарийн зохицуулалт хийгдсэн байна. Ачаа тээшний А ба В ременийг 35,6м-г 60 м болгон уртасгаснаар 2 өргөн биет агаарын хөлгийг 2 ременээр нэгэн зэрэг авах боломжтой болно	Дараах арга хэмжээг санаачлан хэрэгжүүлж нисэх буудлын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэн, ачаалал бөөгнөрлийг бууруулах үр дүнтэй ажлуудыг гүйцэтгэхэд хамтарсан компанид дэмжлэг үзүүлэн ажиллав. Үүнд: 2023 оны батлагдсан Зуны нислэгийн цагийн хуваарийн зохицуулалтын тухайд зуны нислэгийн цагийн хуваарийн Пүрэв гарагт өглөөний нислэгээр (7-9 цагийн хооронд) нисэх буудлын ачаалалтай үеийн хүчин чадлаас давсан нислэгүүд төлөвлөгдсөн байгаа тул “НУБИЭ” ХХК-ийн саналыг тусган дахин	100

	явуулахад хамтарсан компанид дэмжлэг үзүүлэх;		яам/ зөвшөөрөл авсан		зохицуулалт хийх шаардлагатай талаар ИНЕГ-ын цагийн хуваарийн зөвлөлд танилцуулан батлуулсан. “Чингис хаан” ОУНБ-ын ОУ-ын ирэгчдийн танхимын ачаа тээшний 2 ширхэг туузан дамжуулагчийн өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэх гэрээг Япон улсын Daifuku ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр гэрээ байгуулж, Япон улсад үйлдвэрлэсэн удирдлагын төхөөрөмжийг агаараар тээвэрлэж 2023 оны 05 дугаар сарын 08, Хятад улсад үйлдвэрлэсэн туузан дамжуургын бүрэлдэхүүн хэсгүүдийг газраар тээвэрлэж 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрүүдэд тус тус “Чингис хаан” ОУНБ-д хүлээн авч туузан дамжуургын угсралтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 17-ноос эхэлсэн бөгөөд 05 сарын 30-ны өдөр "А" туузан дамжуургын өргөтгөлийн ажлыг, 06 дугаар сарын 08-нд "В" туузан дамжуургын өргөтгөлийн ажлыг тус тус дуусгаж, төлөвлөсөн хугацаанаас 21 хоногийн өмнө ашиглалтанд оруулсан. “Чингис хаан” ОУНБ-ын ирэгчдийн 1 давхрын зорчигчдод зориулсан нийтийн эзэмшлийн талбай болох зорчигчийн паспорт шалгах, ачаа авах зай талбайг 208 м²-аар нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандартаар 156-205 зорчигч нэмэлтээр хүлээн авах талбай юм. Зорчигч бүртгэлийн системийн холболт: Шинэ нисэх буудал барих төслийн хүрээнд Нисэх буудлын зорчигч бүртгэлийн системийн (CUTE) холболтыг утасгүй сүлжээ ашиглан шийдсэн байсан. Энэ нь цаг агаараас шалтгаалан сүлжээ тасалдах, хурд хязгаарлагдмал, хоцрогдол их зэрэг сөрөг талтай байсан учир “НУБИЭ” ХХК нь Arinc компанитай хамтран сүлжээний шилэн кабель руу шилжүүлж, утасгүй холболтыг нөөц холболт болгон шилжүүлсэн. Үр дүн нь цаг агаарын ямар ч нөхцөл байдлаас тасалдал үүсэхгүй болсон, сүлжээний хоцрогдол эрс	
--	---	--	----------------------	--	--	--

					буурсан, өмнөх утасгүй холболтыг нөөц холбоос болгон ашигласан нь найдвартай байдлыг дээшлүүлсэн. Бүртгэлийн цэгийн зорчигч урсгалыг сайжруулж, бөөгнөрлийг багасгах хамтын ажиллагааны үүрэг, хариуцлагын заагийг тодорхойлж, харилцан тохиролцож агаарын тээвэрлэгч буюу “МИАТ” ТӨХК-тай санамж бичгээр харилцан тохиролцож, санамж бичгийн хэрэгжилт, явцын талаар өдөр тутмын ээлжийн тайлан мэдээг “МИАТ” ТӨХК руу илгээж, мэдээлэл солилцон хамтын ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажилласан. Ачаа тээш авах танхимаас гарах хаалганы хэсэгт бөөгнөрөл үүсэхээс зайлсхийхэд Гаалийн үзлэгийн өрөөг буулгаж зорчигчийн гарах хаалганы зайг 33.6м²-аар томруулах шийдлийг олж “IATA”-ийн Оптимум түвшин 12-рт заасны дагуу 18~25 зорчигчийн талбай нэмэгдсэн.	
5.	“Нью Улаанбаатар интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны тайлантай танилцах, судлах, хяналт тавих, дүгнэлт өгөх, компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангах;	Гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээлэл, санал дүгнэлт, танилцуулга Хэрэгжүүлэх хугацаа: Улирал бүр	2022 оны үйл ажиллагааны тайланг улирал бүрээр судалж, компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангасан.	2023 оны үйл ажиллагааны тайланг сар, улирал бүр хүлээн авч судлан, компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангана.	“Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн 2022 оны жилийн санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлантай танилцаж, тус компанийн удирдлагуудтай хэд хэдэн удаагийн уулзалт хийж, тодруулга, тайлбар авснаар санал дүгнэлтийг боловсруулан ТУЗ-д удирдамж, чиглэл өгсөн. 2023 оны бизнес төлөвлөгөө, төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж, сар бүрээр тайлан мэдээг авч, холбогдох саналыг хүргүүлэн ажилласан. Хамтарсан компанийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх асуудлуудыг тухай бүр судлан танилцаж Монголын талын ТУЗ-ийн гишүүдийг удирдамж, чиглэлээр хангаж ажиллан 42 хэлэлцэх асуудлаар 9 удирдамж хүргүүлсэн. <u>Хамтарсан компанийн ТУЗ-ийн хурлаас:</u> ТУЗ-ийн нийт 31 тогтоол гарсны дагуу хэрэгжилтийг хангуулан ажилласан. Уг тогтоолуудаар компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын	100

					тов, “Чингис хаан” ОУНБ-ын Олон улсын явагчийн танхим дахь түрээслэгчдийг шилжүүлж шинээр зорчигчдод зориулсан үйлчилгээний зай талбай гаргах ажлын санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлын талаар, мөн хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, орлон ажиллах эрх олгох, сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл олгох, нэмэлт бүртгэлийн цэг нийлүүлэх, суурилуулах ажлын талаар тус нисэх буудалд ачаа тээшний туузан дамжуургыг анх суурилуулсан үйлдвэрлэгчтэй хэлэлцээ хийх эрх олгох, төсөвт тодотгол хийх, компанийн бүтэц зохион байгуулалт болон худалдан авах ажиллагааны журмыг шинэчлэн батлах, Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт оруулах өөрчлөлтийн талаар, ЖАЛУКС Инк болон ЖАТКО ХХК-тай байгуулах Ажилтан түр шилжүүлэх гэрээг шинэчлэх тухай зэрэг асуудлын талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.	
6.	“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн жилийн бизнес төлөвлөгөө, төсвийг хүлээн авч, судлах, дүн шинжилгээ хийж санал дүгнэлт өгөх, компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангах;	Гүйцэтгэсэн ажлын тайлан, мэдээлэл, танилцуулга Хэрэгжүүлэх хугацаа: 4 дүгээр улиралд	2023 оны төсвийн төслийг судалж, холбогдох санал дүгнэлтийг өгсөн. Үр дүнд бизнес төлөвлөгөө төсвийн төсөлд засвар өөрчлөлт орсон. Хамтарсан компанийн ТУЗ-ын гишүүдэд холбогдох мэдээлэл танилцуулгыг бэлтгэж хүргүүлсэн.	Хамтарсан компанийн дараа жилийн бизнес төлөвлөгөө, төсвийн төслийг өмнөх оны санхүүгийн жил дуусахаас 2 сарын өмнө хүлээн авч танилцаж судлан, санал дүгнэлт өгч ажиллана. Компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангана.	Хамтарсан компани нь дараа жилийн төсвийн төслийг тайлант он дуусахаас 2 сарын өмнө хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх үүрэгтэй. Үүний дагуу 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр бизнес төлөвлөгөөний эхний төслийг хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүдэд ирүүлсэн ба төсөлтэй танилцан хамтарсан компанийн гүйцэтгэх удирдлагатай 2 удаагийн уулзалтыг хийж тодруулга авч, ирүүлсэн тооцоо баримт материалыг судлан холбогдох санал зөвлөмжийг өгч бизнес төлөвлөгөө, төсвийн төслийн хүрээнд ТУЗ-ийн гишүүдэд хүргүүлэх товч танилцуулгыг бэлтгэх зааварчилгааг өгч ажилласан.	100
7.	“Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн батлагдсан төсвийг төсвийн гүйцэтгэл буюу	Гүйцэтгэсэн ажил, тайлан, мэдээлэл танилцуулга	2021 оны жилийн, 2022 оны хагас жилийн санхүүгийн	Санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг улирлаар болон хагас жил, жилийн эцсийн	2022 оны жилийн санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлантай танилцаж, тус компанийн удирдлагуудтай хэд хэдэн удаагийн уулзалт хийж, тодруулга, тайлбар авснаар санал	100

	санхүүгийн тайлан мэдээтэй харьцуулан судлах, компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангах;	Хэрэгжүүлэх хугацаа: Улирал бүр	тайланг судалж, компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангасан.	байдлаар хүлээн авч судлан, компанийн удирдлага, ТУЗ-ийн гишүүдийг мэдээллээр хангана.	дүгнэлтийг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд удирдамж, чиглэл өгсөн. 2023 оны бизнес төлөвлөгөө, төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж, сар бүрээр тайлан мэдээг авч, анхаарах асуудлын талаар тухай бүрт харилцаж тодруулан, холбогдох санал зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Мөн шаардлагатай мэдээ мэдээллийг салбарын яам, холбогдох төрийн байгууллагуудад өгч, тэдгээрт хамтарсан компаниас тайлан мэдээллийг хүргүүлэн ажиллах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	
8.	Хамтарсан компанийн санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарч МУ-ын төсөвт оруулах хувь нэмэр, үр өгөөж, төсөвт төлөх татвар, хураамж, төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх;	Улсын төсөвт төлөх татвар хураамж, концессын төлбөрийн хэмжээ Хэрэгжүүлэх хугацаа: Улирал бүр	2021 оны концессын төлбөр 1.2 тэрбум төгрөг, ААНОАТ-т 331.3 сая төгрөг, 2022 оны концессын төлбөр 4.5 тэрбум төгрөг, ААНОАТ 1.4 тэрбум төгрөг байна	2023 оны концессын төлбөрт 7.8 тэрбум төгрөг, улсын төсөвт ААНОАТ-т 739.7 сая төгрөг төлөхөөр тооцсон.	Хувьцаа эзэмшигчдээс хамтарсан компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, санал зөвлөмж өгч ажилласны үр дүнд: “НУБИЭ” ХХК-ийн 2023 оны үйл ажиллагааны жилийн орлогын нийт дүн гүйцэтгэлээр 124.8 тэрбум төгрөг, концессын төлбөр 11.8 тэрбум төгрөг байна. Концессын төлбөрийг өнгөрсөн 2022 онтой /6.1 тэрбум төгрөг/харьцуулбал 1.9 дахин буюу 193 хувиар өссөн. Хуулийн дагуу төлөх албан татвар, төлбөр, хураамж, шимтгэлээр Улсын төсөвт төвлөрүүлэх нийт орлогын дүн 36.6 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс ААНОАТ-ын дүн 10.0 тэрбум төгрөг.	100
9.	“Чингис хаан” ОУНБ-ын нисэхийн болон нисэхийн бус үйл ажиллагаа нь Олон улсын болон Иргэний нисэхийн дүрмийн шаардлага болон төрийн хяналтын байгууллагуудын зөвлөмж, дүгнэлт шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх.	Хяналт, зөвлөх үйлчилгээний тоо Хэрэгжүүлэх хугацаа: 4 дүгээр улиралд	“Чингис хаан” Олон улсын нисэх буудал нь Иргэний нисэхийн дүрэм /ИНД-139/-ийн дагуу Аэродромын гэрчилгээ эзэмшигч болно.	“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын нисэхийн болон нисэхийн бус үйл ажиллагаа нь Олон улсын болон ИНД-ийн шаардлагыг хангасан байна.	“Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн үзүүлж буй “Чингис хаан” ОУНБ-ын нисэхийн болон нисэхийн бус үйлчилгээ, үйл ажиллагаа нь Олон улсын болон ИНД-ийн шаардлагыг хангасан эсэх талаар тухай бүр мэдээлэл авч, шаардлагатай тохиолдолд газар дээр нь ажиллаж танилцан холбогдох зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажиллаж доорх үр дүнд хүрсэн. - Аэродромын үйл ажиллагааны сайжруулалт: В737-800, МАХ,В737-900МАХ, В777, В787 маягийн агаарын хөлгүүд "ЧХОУНБ"-д нислэг үйлдэхэд тохиромжтой эсэх талаар нисэхийн судалгаа хийж, "НААХЗА"-аар хянуулан, баталгаажуулсан бөгөөд Нисэхийн	100

					мэдээллийн эмхэтгэл дэх “PCN70” гэсэн даацын үзүүлэлтийг “PCN86” болгон өөрчилж олон улсад зарлуулан, B777-300ER, B787-9 агаарын хөлгүүдийг хүлээн авах боломжтой болсон. - ИНҮТ-тэй “Аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г шинэчлэн байгуулсан ба ажилтны тоог 132 ажилтнаас 116 ажилтан болгож багасгасан. - Нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөр”-ийг ИКАО-ын аюулгүй байдлын аудит шалгалт болон АНУ-ын Тээврийн аюулгүй байдлын агентлаг (TSA)-аас хийгдэх аюулгүй байдлын үнэлгээнд хамрагдах Протокол асуултууд болон Аюулгүй байдлын аудитын асуумж (SASAQ)-уудад нийцүүлэн шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, - Иргэний нисэхийн дүрэм 139-ийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын албаны аюулгүй ажиллагааны гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтад 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 20-ны өдрүүдэд хамрагдаж, Аэродромын гэрчилгээг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл буюу 2 жилийн хугацаатайгаар сунгуулсан.	
Хоёр: “Чингис хаан” Олон улсын нисэх буудал дах Хүндэт зочны танхимын үйл ажиллагааг эрхлэн явуулах.						
1.	Хүндэт зочны танхимын үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулж, холбогдох дүрэм, журмын хүрээнд стандарт шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх;	Үйлчилгээ үзүүлсэн зорчигчийн тоо Хэрэгжүүлэх хугацаа: Сар, улирал тутамд	2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 5300 орчим зорчигчдод журмын дагуу үйлчилгээ үзүүлсэн.	Зорчигч үйлчлүүлэгчийн тоо өмнөх оноос өснө.	“ХХНОБ” ТӨХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Компанийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” ХЭХТ22/04 дугаар тогтоолоор Хүндэт зочны алба буюу “Чингис хаан” ОУНБ-ын Хүндэт зочны танхимд ажиллах үйлчилгээний ажилтны орон тоог 22 болгон нэмэгдүүлж үйлчилгээг сайжруулах, хүртээмжтэй, хурдан шуурхай болгох бэлтгэл ажлыг хангасан. Албаны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, хүн хүчийг	100

					нэмэгдүүлснээр үйлчилгээний тасралтгүй, шуурхай, хүртээмжтэй байдлыг хангаж, удирдлага, хяналтыг сайжруулах нөхцөл бүрдсэн. Тус алба нь жилийн эцсийн байдлаар менежер 1, ээлжийн үйлчилгээний 16 ажилтан, үйлчилгээний туслах ажилтан-үйлчлэгч 2, ажилчдын унаа, үйлчилгээний 2 жолооч, нийт 21 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр 24 цагийн тасралтгүй үйлчилгээг үзүүлж байна. Хүндэт зочны танхимын үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор үйлчилгээний стандарт, үйлчилгээний соёл, харилцаа хандлага, хувь хүний хөгжил, байгууллагын соёлын талаарх сургалтуудыг мэргэшсэн сургагч багш нартай хамтран 3 удаа буюу 04 болон 09,11 дүгээр саруудад тус тус, ХАБЭА-н сургалтыг мөн 2 удаа “НУБИЭ” ХХК, ИНЕГ-ын холбогдох нэгж, хэлтэс, мэргэжилтнүүдтэй хамтран үр дүнтэй зохион байгуулсан. “Монголд зочлох жил” буюу “Welcome to Mongolia” Засгийн газрын зорилтот үйл ажиллагааг дэмжин тус аяны лого, тэмдгийг танхимд байршуулж, энгэрийн тэмдэг зүүж, сурталчилгааны мэдээллийг компанийн болон нийт ажилтнуудын цахим хаягаар түгээн ажилласан. “НУБИЭ” ХХК-ийн Зорчигч терминалын газраас 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан “Инээмсэглэн мэндчилж, талархан үдье” уриатай аянд танхимын үйлчилгээний бүх ажилтан хамрагдаж, дэмжин ажилласан ба “Чингис хаан” ОУНБ-ын хэмжээнд идэвхтэй, сайн оролцогчийг шалгаруулахад албаны 2 ажилтан шилдгээр шалгарсан. Мөн 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Чингис хаан” ОУНБ-аас зарласан "Цэмцгэр нисэх буудал" уриатай аянд нэгдэн ажиллав.	
--	--	--	--	--	--	--

					2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 2268 зөвшөөрлийн хуудсаар 7953 зорчигч, үйлчилүүлэгчийг угтан авч, үдэн гаргах үйлчилгээг үзүүлсэн нь өмнөх оны үзүүлэлтээс 41%-иар өссөн байна. Үйлчилгээний танхимд санал гомдлын нээлттэй хайрцаг, санал гомдлын хуудсыг тогтмол байршуулан ээлж солилцох бүрд бүртгэж, хяналт тавин тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Эдгээр ажлын үр дүнд танхимын үйлчилгээнд сэтгэл хангалуун байна, нийт хамт олонд амжилт хүсье гэсэн талархал ирэх болсон. Албаны үйлчилгээний байр, талбай, танхимын тохижилт, тав тух, аюулгүй байдалд ямар нэгэн доголдол, зөрчил гараагүй, танхимд шаардлагатай засвар үйлчилгээг тухай бүр хийлгэж, батлагдсан төсвийн хүрээнд шаардлагатай эд хөрөнгө, бараа материал, багаж хэрэгслээр тухай бүр бүрэн ханган ажилласан.	
2.	Хүндэт зочны танхимаас олох орлогыг нэмэгдүүлэх, орлого нэмэгдүүлэх арга замыг судалж холбогдох байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;	Орлогын өсөлт, бууралтын хэмжээ Хэрэгжүүлэх хугацаа: Хагас жил, жилд	2022 онд Хүндэт зочны танхимын орлогын төлөвлөгөө биелсэн.	Албаны үйлчилгээний журамд өөрчлөлт оруулах саналыг шийдвэрлүүлснээр орлогыг өмнөх оноос нэмэгдүүлнэ.	2023 оны “Хүндэт зочны танхим”-ын үйлчилгээнээс олох жилийн нийт төлөвлөсөн орлого 759.6 сая төгрөг ба 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон дүнгээр 1,056.7 сая төгрөгийн орлого олж, өнгөрсөн жилийн нийт орлогоос 274.8 сая төгрөгөөр давж биелсэн. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар биелэлт 139 хувьтай байгаа нь зорилтот түвшнийг давуулан биелүүлсэн үр дүнтэй. Компани өөрөө өөрийгөө санхүүжүүлэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, алдагдалгүй ажиллах зорилгоор Хүндэт зочны танхимын үйлчилгээний төлбөргүй, хөнгөлөлттэй үйлчлүүлдэг журмыг хүчингүй болгуулах асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагад хандсан ч энэ асуудал шийдвэрлэгдээгүй болно.	100
3.	Хүндэт зочны танхимын үйл ажиллагааг явуулахад шаардагдах ажил, үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар	Хамтран ажилласан, хэрэгжүүлсэн	Холбогдох байгууллагуудтай ашиглалтын болон бусад	Хүндэт зочны танхимын өрөө тасалгаа, эд хогшлын зориулалт, ашиглалт хөдөлмөрийн	Хүндэт зочны танхимын үйл ажиллагааг хэвийн явуулахад хамтран ажиллах шаардлагатай “Чингис хаан” ОУНБ буюу “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК, Агаарын тээвэрлэгч	100

	хийлгэх, “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК, Агаарын тээвэрлэгч компаниуд, төрийн хяналтын байгууллагууд болон Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллагуудтай хамтран ажиллах;	арга хэмжээний тоо Хэрэгжүүлэх хугацаа: Хагас жил, жилд	хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.	аюулгүй ажиллагааны холбогдох дүрэм, стандартын шаардлагыг хангасан байна.	компаниуд, Төрийн хяналт шалгалт, хил гаалийн байгууллагууд болон нисэхийн аюулгүй байдал, хамгаалалтын үйл ажиллагааг хариуцсан байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах, нягт уялдаа холбоотой ажиллах, алдаа зөрчил гаргахгүй байх асуудалд анхаарч хууль, дүрэм журмыг чанд мөрдөн, зөрчил доголдолгүй ажиллаж байна. Тайлант хугацаанд эдгээр байгууллагатай хамтран ажиллах явцад Хүндэт зочны танхимын үйл ажиллагаа, үйлчилгээг зөрчсөн, доголдуулсан ноцтой зөрчил гараагүй.	
4.	“Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд “Чингис хаан” Олон улсын нисэх буудал дахь Хүндэт зочны танхимын гадна орчин, талбайн тохижилт, мод, зүлэг, цэцэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулах.	Зохион байгуулсан ажил, арга хэмжээний тоо Хэрэгжүүлэх хугацаа: 5, 10 дугаар сард	Хүндэт зочны танхимын гадна талбайд 2022 онд 600 хайлаас, зүлэг тарьсан.	Хүндэт зочны танхимын гадна талбайн тохижилт хийгдэж, 600 хайлаас мод нэмж тарьсан байна.	“Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд “Чингис хаан” ОУНБ болон Хүндэт зочны танхимд 2023 онд 4 төрлийн ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж, ажлын төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр баталсан. Төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар жил бүрийн 05 дугаар сарын хоёрдугаар долоо хоногийн Бямба гарагийг “Үндэсний мод тарих” өдөр болгон зарласантай холбогдуулан 05 дугаар сарын 13-ны өдөр компанийн нийт ажилтнууд “Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь “Хүндэт зочны танхим”-ын гадна 300.0м.кв талбайг зүлэгжүүлэн, 200 ширхэг нэг наст цэцгийн мандал, 300 хайлаас мод нэмж суулган, гадна талбайн цэвэрлэгээ, өмнө суулгасан 1200 ширхэг хайлаас, бут модны усалгаа, арчлалтын ажлыг хийж гүйцэтгэв. Гүйцэтгэх захирлын баталсан “Чингис хаан” ОУНБ дахь Төрийн хүндэт зочны танхимын гадна зам талбайн цэвэрлэгээ, ногоон байгууламжийн арчлалтын ажлын хуваарийн дагуу 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Хүндэт зочны албаны үйлчилгээний туслах ажилтнууд Даваа гараг бүр, албаны ажилтнууд сар тутам буюу 2023 оны 01 дүгээр сарын 30; 02 дугаар сарын 26; 03 дугаар сарын 31; 04 дүгээр сарын 20; 07 дугаар сарын 28; 08 дугаар сарын 28; 09 дүгээр	100

					сарын 09, 15; 10 дугаар сарын 30-ны өдрүүдэд, компанийн нийт ажилтан 05 дугаар сарын 13, 10 дугаар сарын 13-ны өдөр тус тус гадна талбайн цас, мөсийг арилгаж, хог хаягдал түүж, их цэвэрлэгээг хийсэн. Өвлийн улирал эхэлсэнтэй холбогдуулан Хүндэт зочны албаны үйлчилгээний ажилтнууд цас орсон тухай бүр Төрийн хүндэт зочны танхимын гадна талбайн цас, мөсийг арилгаж, хог хаягдлыг түүн цэвэрлэгээг хийж хэвшсэн.	
Гурав: УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, компанийн засаглалыг сайжруулах						
1.	УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэр, хууль тогтоомж, дээд шатны болон бусад байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн тогтоол, захирамж, тушаал, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;	Хэрэгжилтийн Хувь Хэрэгжүүлэх хугацаа: Сар бүр	Хууль тогтоомж, үүрэг, даалгавар зэрэг 41 ажил, арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг цаг тухайд нь гаргаж танилцуулсан.	Хууль тогтоомж, тушаал, шийдвэр, Дээд шатны байгууллагын үүрэг, даалгавар, зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн байна.	Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, ЗТХСайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хүрээнд компанийн 2023 онд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээнд дараах төлөвлөгөөг батлан гаргаж, хэрэгжилтийг ханган, заасан хугацаанд тайлагнан ажиллав. Үүнд: “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”, “Зорилтын санал”, “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд хийх ажлын төлөвлөгөө, “Гадаад арга хэмжээний төлөвлөгөө”, “Иргэд, аж ахуйн нэгжид үзүүлж буй үйлчилгээг цахимжуулах ажлын төлөвлөгөө”, “Танхимын болон цахим сургалтын төлөвлөгөө”, ЗТХСайдын 01 дүгээр албан даалгаврын хүрээнд хийх ажлын төлөвлөгөө, “Монголд зочлох жил”-ийн хүрээнд зам, тээврийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ЗТХСайдын 02 дугаар албан даалгаврын дагуу 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Зам, тээврийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ЗТХСайдын 2023 оны 04 дүгээр албан даалгаврын дагуу “ХХНОБ” ТӨХХК-ийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг тус тус гарган хэрэгжилтийг бүрэн ханган заасан хугацаанд тайлагнан ажиллаа. ЗТХСайдын “Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай” 2023 оны 08	100

					дугаар сарын 01-ний өдрийн 05 дугаар албан даалгаврын хүрээнд “ХХНОБ” ТӨХХК-д хамаарах, шууд хэрэгжүүлэх заалт байхгүй ба Хувьцаа эзэмшигчийн зүгээс “НУБИЭ” ХХК-д “Чингис хаан” ОУНБ-ын хувьд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг тайлагнаж ажиллахыг үүрэг болгон даалгаврыг хүргүүлсний дагуу “НУБИЭ” ХХК нь албан даалгаврын хэрэгжилт, явцын талаар тухай бүр ЗТХЯ-ын Салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн Я.Ганцэцэгт gantsetseg@mrt.d.gov.mn цахим шуудангаар шууд тайлагнан ажилласан. Мөн ЗТХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Ш.Мөнхбулганаас 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсний дагуу ЗТХСайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлтийг гарган 12 дугаар сарын 18-ны өдрийн 01/176 дугаар албан бичгээр ЗТХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (“ХШҮДАГ”)-ын дарга А.Мөнхбатад хүргүүлсэн.	
2.	Шинээр батлагдан гарсан хууль тогтоомжтой нийцүүлэн компанийн дотоод дүрэм, журам, стандартыг шинэчилж, хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн хувь Хэрэгжүүлэх хугацаа: Хагас жил, жилд	Шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуультай нийцүүлэн Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчилж, 2022 оны 01 дүгээр сараас мөрдсөн.	Шинээр батлагдсан хуулиудтай нийцүүлэн компанийн дүрэм, журам, стандарт шинэчлэгдэж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.	Компанийн үйл ажиллагаанд хамаарах аливаа хууль, дүрэм журмын өөрчлөлтийг тухай бүр судлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу компанийн эрхэм зорилго, зорилт, зохион байгуулалтын бүтэц, компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, цаг үеийн мэдээ мэдээлэл, ажлын байрны сонгон шалгаруулалт, авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээлэл зэрэг хуульд заасан нээлттэй мэдээллийг компанийн албан ёсны http://www.khkharp.mn цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэн, мэдээлэл авах, танилцах боломжтойгоор хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг 2023 оны 05 дугаар сарын	100

					09, 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 12-ны өдрүүдэд ЗТХЯ-ны ХШҮДАГ-ын мэргэжилтэн Э.Солонго-д "solongoeb16@gmail.com" цахим шуудангаар, 12 дугаар сарын 12-ны өдрийн 01/165 дугаар албан бичгээр тус газарт тус тус хүргүүлсэн.	
3.	Техник технологийн дэвшил, инновацыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж нөхцөлийг судалж, компанийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ;	Хэрэгжилтийн хувь Хэрэгжүүлсэн арга хэмжээ, Хэрэгжүүлэх хугацаа: Сар бүр	Компанийн цахим хуудсаар 7 төрлийн 24 мэдээллийг нийтэд мэдээлсэн. Зам, тээврийн хөгжлийн яам, бусад байгууллагатай ABLE программ, компанийн хэмжээнд ERP, Outlook программ ашиглан мэдээлэл солилцох, хүлээн авах ажлыг зохион байгуулж байна.	Компанийн ажиллагаанд үйл техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, явуулна. шуурхай	ЗТХЯ-тай цахимаар харилцаж, албан харилцааны шуурхай байдлыг ханган ажиллаж байна. Салбарын мэдээллийн нэгдсэн санд хүний нөөцийн мэдээллийг бүрэн оруулсан. Компанийн дотоод үйл ажиллагаанд цахим хаягийг тогтмол ашиглаж байна. Мэдээллийн шуурхай, нээлттэй байдлыг хангах зорилгоор цахим хуудсуудыг ашиглаж, 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд ажлын байрны сонгон шалгаруулалтын 17, цаг үеийн 57 мэдээ, мэдээлэл, бусад ил тод мэдээлэх шаардлагатай 69 мэдээллийг компанийн https://khkhap.mn/content цахим хуудаст, компанийн болон зам, тээврийн салбарын үйл ажиллагаатай холбоотой нийт 270 мэдээллийг “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” фэйсбүүк хуудаст, шилэн данс буюу www.shilendans.gov.mn -д заавал байршуулах 23 төрлийн 155 мэдээ, тайланг тус тус байршуулав.	100
4.	Компанийн дотоод бүтэц зохион байгуулалт, ажил үүргийн оновчтой, зөв хуваарилалтыг хийж, ажилчдын ажлын бүтээмж, чанар үр дүнг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	Хэрэгжилтийн хувь Хэрэгжүүлэх хугацаа: 1, 2 дугаар улиралд	ХЭХТ-21/05 тогтоолоор батлагдсан бүтцийн дагуу ажиллаж байна.	Компанийн бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн батлуулж, ажил үүргийг оновчтой зөв хуваарилж, ажлын чанар үр дүнг сайжруулна.	“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн ХЭХТ 22/04 дугаар тогтоолоор Санхүү, Захиргаа удирдлагын хэлтэс, Нисэх буудлын зохицуулалтын хэлтэс, Хүндэт зочны алба, нийт 2 хэлтэс, 1 албатайгаар бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн, нийт 41 ажилтны орон тоог хэвээр хадгалж, нэг хэлтэс буюу удирдах албан тушаалтан, оффисын орон тоог хасаж, үйлчилгээний ажилтны орон тоог нэмэгдүүлсэн. Компани нь тайлант оны санхүүжилтийн тодорхой хэсгийг зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх болсонтой уялдан санхүүгийн хүндрэл, эрсдэлээс сэргийлэх	100

					зорилгоор оны эхнээс батлагдсан орон тоог хэмнэх бодлого баримтлан, компанийн Санхүү, Захиргаа удирдлагын хэлтэс өөр дээрээ ачааллыг үүрч, хэлтсийн нийт 6 орон тоог хэмнэсэн ба Үүнд: Хэлтсийн дарга компанийн захиргаа, санхүүгийн үйл ажиллагааг бүхэлд нь удирдан зохион байгуулахын зэрэгцээ, хууль эрхзүйн болон санхүүгийн мэргэжлийн ажил үүрэгт давхар оролцон, Ерөнхий нягтлан бодогч тооцооны нягтлан бодогчийн ажил үүргээ давхар гүйцэтгэж, Эдийн засагч нярвын үүргийг, Архив, бичиг хэргийн ажилтан захирлын туслахын ажил үүргийг хавсран гүйцэтгэн, мөн жолоочийн 1 орон тоог хэмнэх зэргээр зохицуулалтыг хийсэн. Мөн Хүндэт зочны албаны дарга болон захиалгын мэргэжилтэн, үйлчилгээний туслах ажилтны тус бүр 1, нийт 3 орон тоог хэмнэж цалингийн зардлыг хэмнэсэн. Нярав, Гүйцэтгэх захирлын туслахын 2 орон тоог ажилтны ажил үүрэг, ажлын ачааллыг харгалзан Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар цалингийн 20 хувийн нэмэгдэлтэйгээр хавсран гүйцэтгүүлж байна. Компанийн хэмжээнд нийт 9 орон тоог хэмнэснээр цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг бодитоор бууруулж зардал хэмнэсэн. 2023 оны жилийн гүйцэтгэлээр цалин хөлсний зардлыг 25 хувиар хэмнэсэн байна.	
5.	Хүний нөөцийн чадавх, сургалт хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ажилчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх;	Хэрэгжилтийн хувь Хэрэгжүүлэх хугацаа: Улирал тутамд	2021 онд цахим сургалтад ажилтнууд 100 хувь хамрагдсан.	Хүний нөөцийн чадавх, ажилтны ажил мэргэжлийн чадварыг дээшлүүлэх, тасралтгүй боловсролыг хангах сургалт хөтөлбөрт тогтмол хамрагдах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Компанийн ажилтнуудад компанийн үндсэн үйл ажиллагааны болон нисэх буудлын үйлчилгээний талаарх мэдлэг олгох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, багаар ажиллах чадварыг сайжруулж хамт олонд зөв хандлага нэвтрүүлэн компанийн засаглалыг сайжруулах зорилгын хүрээнд “Компанийн 2023 оны танхимын болон цахим сургалтын төлөвлөгөө”-г 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр батлуулан төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэн дараах сургалт хөгжлийн арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Үүнд:	100

					Нисэх буудлын зохицуулалтын хэлтсийн дарга А.Баасандагва нь 2023 оны 01 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд “Компанийн засаглалын гэрчилгээ олгох” сургалтад хамрагдсанаар Компанийн засаглалын талаарх мэдлэг чадвар эзэмшиж, ТУЗ-ийн гишүүнээр холбогдох хууль, эрх зүй, дүрэм, журмын хүрээнд ажиллах боломж бүрдсэн; Нисэх буудлын зохицуулалтын хэлтсийн дарга А.Баасандагва, Санхүү, Захиргаа удирдлагын хэлтсийн Ерөнхий нягтлан бодогч Д.Дэлгэрмаа, Эдийн засагч Б.Цогт нар 2023 оны 05 дугаар сарын 17, 18, 19-ний өдрүүдэд Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх танхимын сургалтад амжилттай хамрагдаж Д.Дэлгэрмаа 2023/АЗ-2280, А.Баасандагва 2023/АЗ-2237, Б.Цогт 2023/АЗ-2244 дугаартай АЗ гэрчилгээг тус тус авснаар компанийн хувьцаа эзэмшигчдийн тогтоолоор баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдах авах тухай хууль”-ийн хүрээнд зохион байгуулах нөхцөл бүрдсэн; 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр “Харилцааны соёл ба хандлага” сэдэвт 3 цагийн танхимын сургалтыг Боловсролын удирдлагын арга зүйч, Нийгмийн сэтгэл судлаач Х.Доржханд багштай хамтран зохион байгуулж, компанийн Хүндэт зочны албаны үйлчилгээний 18 ажилтныг бүрэн хамруулав. Уг сургалтыг авснаар үйлчилгээний ажилтнуудын харилцааны соёл, харилцах ур чадварыг нэмэгдүүлж, эерэг сэтгэлгээ, ёс суртахууныг төлөвшүүлэн хэвшүүлснээр үйлчилгээний чанарын түвшинг дээшлүүлсэн; Засгийн газраас зарласан “Монголд зочлох жил”, “Чингис хаан” ОУНБ-ыг олон улсын Скайтракс байгууллагаас “Гурван од” зэрэглэл авах, гадаадын зочид, төлөөлөгчдөд тав тухтай	
--	--	--	--	--	---	--

					орчинд найрсаг, шуурхай үйлчилгээ үзүүлж, сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд “Чингис хаан” ОУНБ дахь Төрийн хүндэт зочны албаны үйлчилгээний ажилтнуудын үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулж, үйлчилгээний стандартад нийцсэн цаг ашиглалт бүтээмжийг дээшлүүлэх, эерэг сэтгэлгээг бий болгож, найрсаг харилцаа, эерэг уур амьсгалыг бүрдүүлэх үүднээс Боловсролын удирдлагын арга зүйч, нийгмийн сэтгэл судлаач Х.Доржханд багш 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр компанийн 28 ажилтанд “Хувь хүний менежмент, эерэг сэтгэлгээ” сэдэвтэй гурван цагийн сургалтыг олгосон; 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр “Көүч Лаб” сургалтын байгууллагын үүсгэн байгуулагч, Мастер трэйнер, Бизнес көүч, “BNI Монгол” байгууллагын үүсгэн байгуулагч Э.Чинзоригтой хамтран “<i>Байгууллагын соёл хэрхэн бий болдог вэ</i>” сэдэвт 2 цагийн танхимын сургалтыг зохион байгуулав. Сургалтад компанийн нийт 30 ажилтан хамрагдан байгууллагын “энгэйжмент”-ийн ойлголт, байгууллагын соёлыг бүрдүүлдэг хүчин зүйлс, эерэг хандлага бүтээмжид хэрхэн нөлөөлдөг болох талаар мэдлэг, мэдээлэлтэй болж сургалт үр дүнтэй, амжилттай зохион байгуулагдлаа; Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 тоот тушаалын дагуу компанийн нийт ажилтнуудыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамруулах шаардлагын хүрээнд аюулгүй ажиллах дадал, хандлага төлөвшүүлж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалах, эрүүл ахуй халдвар хамгаалал зэрэг зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н мэдлэг олгох, мэдлэгийг хэвшүүлэх зорилготой “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвтэй сургалтыг “Нью	
--	--	--	--	--	---	--

					Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан Н.Батчимэгтэй хамтран явуулж 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр компанийн 21 ажилтан, 2023 оны 09 дүгээр сарын 20 өдөр нийт 28 ажилтныг хамруулсан; “Нью Улаанбаатар Интернэшнл Эйрпорт” ХХК-ийн галын албаны мэргэжилтэн Орхонтуяа 2023 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр компанийн нийт ажилтнуудад гарч болзошгүй галын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гал унтраах хэрэгслийг ашиглах, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ зэрэг галын аюулгүй байдлын зааварчилгааг олгож, ажилтнуудын галын аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлсэн бөгөөд НУБИЭ Галын албаны бие бүрэлдэхүүнтэй хамтран гал түймрийн дадлага сургуулилтыг зохион байгуулсан. Галын эрсдэлтэй ажил үйлчилгээ явуулах үеийн галын аюулгүй байдлыг ханган ажиллах үүднээс АААБГ-аас галын эрсдэлтэй ажил үйлчилгээ хийх зөвшөөрлийн хуудас бөглүүлж, АБХТ /71287350/-д өгөх, харин гал гарсан үед 71287311 дугаарт мэдээлэх талаар ойлголттой болсон; Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр баталсан “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх” тухай зарлигийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Боловсрол соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар нээлттэй мэдлэг боловсролын сан, мэргэжлийн багш нарын 2015 онд бэлтгэн гаргасан Монгол бичгийн 40 цуврал цахим хичээлийг бие даан судлуулахаар компанийн нийт ажилтнуудад сар бүр тогтмол, цахимаар хүргүүлсэн. 2023 оны 1-6 дугаар сард нийт 10 удаагийн 1 цаг 30 минутын цахим хичээлийг нийт ажилтнуудад хүргэж судлуулсан;	
--	--	--	--	--	--	--

					Чой.Лувсанжавын нэрэмжит Хэл Иргэншлийн Эрдмийн хүрээлэнгийн багш, хэл шинжлэлийн ухааны магистр Б.Амгалан "Хөшигийн Хөндийн Нисэх Онгоцны буудал" ТӨХХК-ийн нийт ажилтнуудад Монгол бичгийн анхан шатны 15 цагийн танхимын хичээлийг 2023 оны 10 дугаар сарын 17-27-ны өдрүүдэд амжилттай зааж гүйцэтгэсэн болно. Монгол бичгийн үндсэн зурлага, хэмжээ харьцаа, Цагаан толгой, Дэвсгэр үсэг, Нэрийн нөхцөлийг зөв дагуулах, Гар утасны хэрэглүүрүүд ашиглах, Оффисын програмд монгол бичгээр шивж сурах зэрэг чадварыг эзэмшсэн болно. Сургалтын үр дүнг Mongolian Baiti фонтоор тодорхой эх бичүүлж тооцсон бөгөөд Монгол бичгийн анхан шатны танхимын хичээлийг амжилттай дүүргэсэн тул байгууллага нь сертификат гардан авсан.	
6.	Компанийн архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэх, цаасан суурьтай баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх;	Хэрэгжилтийн хувь Хэрэгжүүлэх хугацаа: Сар тутамд	2021 онд цаасан суурьтай 21 нэр төрлийн 41 баримт бичгийг архивлаж, 6 төрлийн баримт бичгийг цахим архивын нэгж болгосон.	Компанийн баримт бичиг архив, албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хөтөлж, цаасан болон цахим архивын нэгжтэй болсон байна.	Компанийн 2022 оны үйл ажиллагаанд хамаарах 25 нэр төрлийн 46 хавтас баримт бичгийг архивын зааврын дагуу хадгаламжийн нэгж болгон архивласан. Үүнд: 1. Гүйцэтгэх захирлын А тушаал-1 боть; 2. Б тушаал-1 боть; 3. Гүйцэтгэх захирлын шуурхай хурал-1 боть; 4. Гэрээ-1 боть; 5. Ирсэн албан бичгийн-4 боть; 6. Явуулсан албан бичгийн-4 боть; 7. Төлөвлөгөө тайлангийн биелэлт-2 боть; 8. Үйл ажиллагааны тайлан-1 боть; 9. Оффис түрээсийн тендерийн материал- 1 боть; 10. Хувьцаа эзэмшигчдийн хурал-1 боть; 11. Сайдын шуурхай хурал-1 боть; 12. Ажлын байрны тодорхойлолт -1 боть; 13. Ажлаас чөлөөлөгдсөн ажилчдын хувийн хэрэг 3 боть; 14. Захиргааны хэлтсийн ажлын тайлан 1 боть; 15. Гүйцэтгэх захирлын тушаалын төсөл 1 боть; 16. Өргөдөл 1 боть;	100

					17. Үйл ажиллагааны тайлан 1 боть; 18. Хөдөлмөрийн гэрээ 1 боть; 19. Төрийн банкны харилцахын баримтууд – 2 боть; 20. Хаан банкны харилцахын баримтууд – 6 боть; 21. Кассын баримт- 3 боть; 22. Бараа материалын баримт- 3 боть; 23. Санхүүгийн тайлан -1 боть 24. Нийгмийн даатгалын тайлан, цалингийн баримт-3 боть; 25. Үндсэн хөрөнгийн баримт 1 боть. 2023 онд ирсэн 171 албан бичигт бүртгэл хяналтын карт нээж бүртгэн удирдлагад танилцуулж, өгсөн чиглэлийн дагуу Санхүү, Захиргаа удирдлагын хэлтэст 98, Нисэх буудлын зохицуулалтын хэлтэст 73 албан бичгийг цахимаар хүргүүлсэн. Үүнээс 39 хариутай албан бичиг ирснийг хариуг 100 хувь хуулийн хугацаанд цахимаар болон цаасаар хүргүүлсэн. 182 албан бичгийг холбогдох байгууллагуудад баримт бичгийг стандартын дагуу хэвлэмэл хуудсанд эцсийн байдлаар үйлдэж, баримт бичгийн бүрдлийг /гарын үсэг, тамга, тэмдэг/ хангаж дугаар өгч, цахимаар болон цаасаар хүргүүлж, цахим архивын нэгж болгов.	
7.	Ажилтны нийгмийн асуудал, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр сургалт арга хэмжээ болон бусад ажлыг зохион байгуулах;	Зохион байгуулсан ажил, арга хэмжээний тоо Хэрэгжүүлэх хугацаа: Хагас жил, жилд	Эрүүл мэндийн үзлэгт 27 ажилтан, 5 төрлийн шинжилгээ 28 ажилтан, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын 4 сэдэвт цахим сургалтад 28 ажилтан хамрагдсан.	Ажилтан бүрийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулж, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтад бүрэн хамруулсан байна. Үйлчилгээний ажилтнуудыг улирал бүр тогтмол үзлэг шинжилгээнд хамруулна	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зардал хэмнэн мөнгөн хөрөнгийн хүрэлцээг хангах нөхцөл шаардлагатай уялдан 2023 оны зардлыг төсөвлөн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцөл, эрүүл ахуй, аюулгүй байдал, ажлын цагийн зөв зохион байгуулалт, цалин хөлсний хэмжээ ажлын байрны үүрэг хариуцлага, ажлын ачааллын уялдаа холбоог сайжруулах, ажилтныг урамшуулах тогтолцоог бий болгоход чиглэсэн ажил, арга хэмжээний ойрын болон хэтийн бодлого төлөвлөлтийг компанийн санхүүгийн	100

					нөхцөл байдалтай уялдуулан үе шаттайгаар хэрэгжүүлэн ажилласан. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтанд ажилласан жилийн нэмэгдэл, ажилласан өдрөөр хоол, унааны хөнгөлөлтийг тооцоолон цалин хөлс дээр нэмж олгож байна. Эдийн засгийн нөхцөл байдал, инфляцын огцом өсөлтийг харгалзан 2023 оны 01 дүгээр сараас эхлэн нийт ажилтнуудын цалин хөлсийг 5-20 хүртэл хувиар нэмэгдүүлсэн. Ажилтны нийгмийн асуудал, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр компанийн нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх багцын үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг 2023.05.10-06.10-ны өдрүүдэд 1 сарын хугацаанд зохион байгуулж, “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн 22 ажилтан эрүүл мэндийн урьдчилан багцын үзлэг, шинжилгээнд “Сөүлсэниорс Монголиа” эмнэлэгт хамрагдсан. “Чингис хаан” ОУНБ дахь Төрийн үйлчилгээний Хүндэт зочны албаны үйлчилгээний ажилтнуудыг хагас жил тутам эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд (сүрьеэ-рентген, цагаан хорхой, нян тээгч, хамар залгиурын арчдас, арьсны халдварт өвчин) хамруулахаар хамтран ажиллах гэрээг Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвтэй байгуулж, гэрээнд заасан хуваарийн дагуу 2023 оны 02.13-14, 2023 оны 08 дугаар 08, 09, 14-ний өдрүүдэд Хүндэт зочны үйлчилгээний албаны 19 ажилтан үзлэг, шинжилгээнд бүрэн хамрагдсан. Замын хөдөлгөөнд оролцохоос өмнө авто тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, тээврийн хэрэгсэл болон жолооч өөрийн хувийн бэлтгэлийг хангах гэх мэт замын хөдөлгөөний, аливаа осол, эрсдэлээс урьдчилан	
--	--	--	--	--	--	--

					сэргийлэхэд чиглэсэн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, санамж, ажил үүрэгтээ өдөр тутамд мөрдөх дүрэм журмыг жолооч нарт сар бүр тогтмол өгч, баримтлах дадлыг хэвшүүлсэн. Хүндэт зочны албаны 19 үйлчилгээний ажилтанд улирал бүр бичгээр эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч хэвшсэн. Монгол Улсын Шадар сайдын Ажлын алба, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газрын хамтран 2023 оны 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд Стратегийн команд штабын сургууль хийгдсэн бөгөөд компанийн оффисын ажилтнууд 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр 16:00 цагт Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагдсан тус дадлага, сургуулилтад хамрагдсан болно.	
8.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулах.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь Хэрэгжүүлэх хугацаа: Сар бүр	2022 онд нийт 57 өргөдөл бүртгэж хяналтад авч, шийдвэрлэсэн. дундаж хугацаа 9, 2 хоног байсан.	Хяналтад авсан өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх оны түвшинд барьсан байна.	Компанид болон компанийн удирдлагад хандсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал байхгүй болно.	100
Дөрөв. Санхүүгийн ил тод байдлыг хангах, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу хөтлөх						
1.	Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын багц хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, Санхүү, татварын тайланг сар, улирал, хагас жил, жилээр гаргаж, хуулийн хугацаанд тайлагнах, улсын төсөвт төлөх төлбөрийн үүргийг хуулийн хугацаанд нь биелүүлэх;	Санхүү, татварын тайлангийн төрөл, тоо Хэрэгжүүлэх хугацаа: Сар, улирал, хагас жил, жилд	Сар бүр -2, улирал бүр -5, хагас жил -5, жилээр -5 батлагдсан маягтын санхүү, татварын тайлан бэлтгэдэг Хэрэгжүүлэх хугацаа:	Батлагдсан маягтын дагуу санхүү, татварын тайланг сар, улирал, хагас жил, жилээр гаргаж, тайлагнасан байна.	Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар санхүүгийн тайлан, мэдээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын хуулиуд, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад журамд нийцүүлэн үнэн зөв, алдаагүй бэлтгэн гаргаж, хуулийн хугацаанд тайлагнасан. Хувьцаа эзэмшигчид буюу харьяа дээд шатны байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлсэн.	100

2.	Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;	Шилэн дансны мэдээллийн төрөл, Тоо Хэрэгжүүлэх хугацаа: Сар, улирал, хагас жил, жилд	2022 онд тухай бүр 10 төрлийн 120, сар бүр 3 төрлийн 30, улирал бүр 1 төрлийн 4, хагас жилээр 3 төрлийн 3, бүтэн жилээр 5 төрлийн 5, нийт 162 мэдээлэл оруулсан. Хэрэгжүүлэх хугацаа:	Төсвийн гүйцэтгэлийн мэдээ мэдээллийг нийтэд ил тод мэдээлж, холбогдох байгууллагад тайлагнасан байна.	Тайлант оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайланг бэлтгэж эрх бүхий байгууллагад тайлагнасан. Шилэн дансны тухай хуулийн дагуу 2023 онд шилэн дансанд тухай бүр 10 төрлийн 120, сар бүр 2 төрлийн 24, хагас жилээр 3 төрлийн 3, бүтэн жилээр 8 төрлийн 8, нийт 23 төрлийн 155 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан. Хугацаа хоцроосон болон байршуулаагүй мэдээ байхгүй. Худалдан авах ажиллагааны тайланг нийтэд ил тод холбогдох цахим талбаруудад жилээр тайлагнасан. Шилэн дансны тайланг улирал бүр гаргаж 2023.04.20-ны өдрийн 01/58, 2023.07.07-ны өдрийн 01/94, 2023.10.09-ний өдрийн 01/128, 2024.01.15-ний өдрийн 01/15 дугаар албан бичгүүдээр Зам тээвэр, хөгжлийн яаманд болон Сангийн яаманд хүргүүлсэн.	100
3.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлж ажиллах, компанийн санхүү, мөнгөн урсгалыг үр ашигтай удирдан зохион байгуулах;	Тайлант хугацааны санхүүгийн үр дүн Хэрэгжүүлэх хугацаа: Сар, улирал бүр	2022 онд нийт зардлын 30%, хөрөнгө оруулалтыг 70% хэмнэсэн. Хэрэгжүүлэх хугацаа:	Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангаж, зөрчилгүй ажиллана.	Төрийн хэмнэлтийн хуульд заасны дагуу хэмнэлтийг хэрэгжүүлэх зарчмыг мөрдлөг болгон ажиллаж компанийн санхүү, мөнгөн урсгалыг үр ашигтай удирдан зохион байгуулахыг зорин ажилласан. Компанийн жилийн үйл ажиллагааны зардалд 1,738.9 сая төгрөг зарцуулагдахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,301.2 сая төгрөгийн зардал гарч 595.7 сая төгрөг буюу 31 хувийн зардлын хэмнэлттэй ажилласан. Нийт зардалд ерөнхий удирдлагын зардалд 696.8 сая төгрөг, Хүндэт зочны танхимын үйл ажиллагааны зардал 558.1 сая төгрөг, элэгдлийн зардал 46.3 сая төгрөг, орлогын албан татварын зардал 1.4 сая төгрөг байна. Компанийн бүтэц, орон тоог хэмнэх, ажил, албан тушаалыг хавсран, хослон гүйцэтгүүлэх зэргээр нийт 32 ажилтантайгаар, 9 хүний орон тоог хэмнэн цалингийн зардлыг 25 хувиар бууруулан, 256 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.	100
4.	Цалин хөлсний сүлжээг компанийн онцлог, нэгж хэлтэс, ажлын байр албан	Хэрэгжилтийн хувь	2019 онд батлагдсан цалингийн	Цалингийн сүлжээг бүтцийн өөрчлөлт, инфляцын түвшинтэй	Компанийн ажилтнуудын цалингийн сүлжээг батлагдсан төсвийн хүрээнд Гүйцэтгэх захирлын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Б/33	100

	тушаалын ажил үүргийн хуваарь, ажлын ачаалал, хариуцлага, үр дүнтэй уялдуулах, инфляцын түвшинг харгалзах байдлаар оновчтой тогтоож, шинэчлэн мөрдүүлэх;	Хэрэгжүүлэх хугацаа: 1 дүгээр улиралд	сүлжээг мөрдөж байна.	нийцүүлэн шинэчлэн мөрдөнө.	дугаар тушаалаар шинэчлэн баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөн ажилласан. Үүнд, нийт ажилтны цалинг 5-20 хүртэл хувиар, албан тушаалын доод шатлалын цалинг 20 хувиар, албан тушаалын дээд шатлалыг 5-10 хүртэл хувиар нэмэгдүүлэх бодлогыг баримталсан.	
5.	Компанийн 2023 оны санхүүжилтийг хамгийн боломжит, өөрт ашигтай арга замаар шийдвэрлэх, өөрийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судалж шийдэлд хүрэх;	Хэрэгжилтийн хувь Хэрэгжүүлэх хугацаа: Хагас жил, жилд	2022 оны Хүндэт зочны үйлчилгээний орлогын төлөвлөгөө биелсэн	2023 оны санхүүжилтийг шийдвэрлэнэ. Өөрийн орлогын эх үүсвэр буюу ХЗТ-ын орлогыг өмнөх оноос нэмэгдүүлнэ.	2023 оны жилийн дүнгээр Хүндэт зочны танхимын үйлчилгээний болон бусад төлөвлөсөн орлого 759.6 сая төгрөг байхаас гүйцэтгэлээр 1056.8 сая төгрөгийн орлого олж, орлогын төлөвлөгөөг 297.2 сая төгрөгөөр давуулан биелүүлж, зорилтот түвшний орлогын үзүүлэлтийг 39 хувиар давуулан биелүүлсэн. Компани өөрөө өөрийгөө санхүүжүүлэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, алдагдалгүй ажиллах зорилгоор Хүндэт зочны танхимын үйлчилгээний төлбөргүй, хөнгөлөлттэй үйлчлүүлдэг журмыг хүчингүй болгуулах асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагад хандсан ч энэ асуудал шийдвэрлэгдээгүй болно. Компани 2024 оноос эхлэн хувьцаа эзэмшигчийн үйл ажиллагаанаас орлого олох боломжтой болсон.	100
6.	Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитыг хуульд заасан хугацаанд хийлгэж, аудитаар баталгаажсан жилийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт хуулийн хугацаанд эрх бүхий этгээдүүдэд хүргүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж хэлэлцүүлэх, батлуулах;	Жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмж Хэрэгжүүлэх хугацаа: Эхний хагас жилд	Өмнөх жилүүдэд жилийн санхүүгийн тайлангийн аудитыг хуулийн хугацаанд хийлгэж, зөрчилгүй дүгнэлт авч ажилласан.	Тайлант оны жилийн санхүүгийн тайлангийн аудитыг хийлгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлуулна.	2022 оны жилийн санхүүгийн тайланг НББОУС (Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт), Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын хуулиуд, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв, алдаагүй бэлтгэн гаргаж, хуулийн хугацаанд зөрчилгүй, үнэн зөв тайлагнаж баталгаажуулан, Үндэсний аудитын газар ("ҮАГ")-ын аудитаар "Зөрчилгүй" тайлан, дүгнэлт авсан. ҮАГ-ын 2022 оны жилийн санхүүгийн тайланд өгсөн аудитын 4 зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж тайланг 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр 01/108 дугаар албан бичгээр тус газарт, 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/100 дугаартай албан бичгээр ЗТХЯ-	100

					ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст тус тус хүргүүлсэн. Хувьцаа эзэмшигчдийн хуралд 2023 оны 04 дүгээр сарны 19-ний өдөр танилцуулж, Гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлтийг ХЭХТ-23/01 дугаар тогтоолоор батлуулсан.	
7	Эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, арчлалт, хамгаалалтыг сайжруулах, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого бүртгэлийг тогтсон хугацаанд тогтмол хийж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	Тооллогын тоо, үр дүн Хэрэгжүүлэх хугацаа: Хагас жил, жилд	2022 онд үндсэн хөрөнгийн тооллого 1 удаа, бараа материалын тооллогыг 2 хийж дүгнэлт гаргасан.	Компанийн өмч, эд хөрөнгийн ашиглалт, арчлалт, хамгаалалт сайжирна.	Компанийн 2023 оны эхний хагас жилийн бараа материалын тооллого хийх тухай Гүйцэтгэх захирлын 2023.06.26-ны өдрийн А/09 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдрийн хооронд компанийн данс бүртгэлд бүртгэлтэй бараа материал болон кассын бэлэн мөнгөний үлдэгдлийн тооллогыг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хийж, тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, үр дүнг тайлагнасан. Үндсэн хөрөнгө болон мөнгөн хөрөнгийн жилийн эцсийн тооллого явуулах тухай Гүйцэтгэх захирлын 2023 оны А/18 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс компанийн үндсэн хөрөнгө, бараа материал болон мөнгөн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг 12 дугаар сарын 25-28-ний өдрүүдэд хийж 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хянаж тулган "Үндсэн хөрөнгө, бараа материал, мөнгөн хөрөнгийн тооллогын тайланг" компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцэн баталгаажуулсан.	100
Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөний хүрээнд нийт 28 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсний дагуу биелэлтийг ханган ажилласан ба гүйцэтгэл 100 хувь байна.						100 %

---ooOoo---